ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ ДУГААР

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,119.373... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.12.05. Даваа. №220, 221 (4590, 4591) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЗЭЛ БОДОЛ

УБЦТС ТӨХК-ИЙГ БАРАА СУДЛААЧААР УДИРДУУЛСНЫ ЦААНА ХУВЬЧЛАХ ХУЙВАЛДААН НУУГДАЖ БАЙНА УУ

III нүүрт

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

З.БАТЗОРИГ: ХҮНИЙ ТӨЛӨӨ ЭДИЙН ЗАСГИЙГ ЦОГЦЛООЖ, ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ЗӨВ БОДЛОГО БАРИМТАЛНА

VI-VII нүүрт

Дугаарын 60 мөр

## Залбирч ч сураагүй байж шашин шүтнэ гэж байх уу

О.УЯНГА

Уг нь монголчууд бид бурхны шашинтай хүмүүс. Тэр дундаа шарын шашныг шүтэх болсоор чамгүй олон жилийг өнгөрөөж. Сүүлийн жилүүдэд элдэв өөр шашин шүтэх хүмүүсийн тоо нэлээд нэмэгдэж байгааг эс тооцвол шүү дээ. Гэхдээ сүүлийн үед бид чинь шашнаа яг шүтэж чадаж байгаа бил үү гэж эргэлзэхэд хүрээд байна. Ядаж л зөв мөргөж чаддаг эсэх нь ч эргэлзээтэй. Хүмүүсийн зарим нь алгаа хавсраад, нөгөө хэсэг нь гараа салаавчлаад л мөргөж, сүсэглэж харагддаг. Эсвэл хавсарсан алгаа нүүрэн хэсэгтээ барьдаг. Үгүй бол цээжний орчимдоо бариад залбирч байгаа нь ч харагддаг. Нөгөө хэсэг нь хавсарсан алгаа бараг л салтаандаа хийчихээд суугаад байгаа нь харагдаж л байдаг. Гэтэл залбирахдаа алгаа хавсрах ёстой юм уу, эсвэл өөрөөр барих юм уу.

Үргэлжлэл нь III нүүрт

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ юуны учир гишүүдийг талцуулав

–Хилийн зурвас дээр газар ашиглуулна гэв–

Ж.ОТГОН
Н.БАТЗАЯА

УИХ-ын баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж, хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороо, гадаад бодлын байнгын хороонд шилжүүлснээр УИХ-ын чуулган завсарласан юм. Энэхүү хуулийн төсөл өргөн баригдсан цагаасаа эхлээд нэлээд маргаан дэгдээгээд байгаа юм. Тухайлбал, Хилийн цэргийг хилийг цагдаа болгож, Монгол Улсын хамгийн чухал салбар болох хил хамгаалах салбарыг хүчгүй болгох гэж байна. Өөрөөр хэлбэл, хилчдийг ямар нэгэн зэвсэггүй гав, бороохойтой буюу “гар нүцгэн” болгох нь гэсэн шүүмжлэл дагуулаад байгаа. Түүнчлэн энэ хуулийн цаана хилийн зурвас орчмын уул уурхайн орд газруудыг ашиглах зорилгоор хуульд өөрчлөлт оруулж байна гэх мэдээлэл ч гараад байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Талын мэлтсийн орд, Хатан суудлын алт, зэсийн ордууд байгаа гэх. Эдгээр ордууд хилээс 20 км зайтай бөгөөд Хилийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Гадаадын иргэн харьяатын газраас хилийн шалгалтын чиг үүргийг буцаагаад хилийн цэрэгт өгөх, хилийн бүс 100 км байсныг үгүй болгох гэж байна гэх зэрэг олон шүүмжлэл дагуулж байгаа. Тухайн хуулийн цаана юу нуугдаж байгааг сайн мэдэхгүй юм. Юутай ч чуулганы нэгдсэн хуралдаанаар энэхүү асуудлын талаар УИХ-ын гишүүд хэрхэн байр сууриа илэрхийлснийг ямар нэгэн хачиргүйгээр хүргэж байна.

Үргэлжлэл нь IV-V нүүрт

ДЭЛХИЙ

## Дэлхийн хэвлэлүүд С.Амармандахын асуудалд анхаарал хандуулав

Б.ДАВААХҮҮ

Өвөрмөц дуулалт, хувцаслалтаараа бусдаасаа ялгардаг “Хар сарнай” хамтлагийн ахлагч С.Амармандах “Аз жаргалтай Улаанбаатар” тоглолтод оролцсоныхоо дараа бусдад зодуулсны улмаас тархиндаа хүнд гэмтэл авсан талаар түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгч нь олон нийтэд мэдээлсэн билээ.

Үргэлжлэл нь IX нүүрт


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

САЙД ЯРЬЖ БАЙНА

## Ц.МӨНХ-ОРГИЛ: УИХ-ЫН ДАРГА М.ЭНХБОЛДОД ИТГЭХ ХЭРЭГТЭЙ

Ж.ОТГОН

*Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилтой цөөн хором ярилцлаа.*

**-Далай ламын айлчлалтай холбоотойгоор олон янзын мэдээлэл цацагдаж байгаа. Түүний энэ удаагийн айчлалтай Засгийн газар ямар нэгэн байдлаар хамаатай юу?**

-Айчлалтай холбоотой худал, үнэн олон л мэдээлэл цацагдаж байна. Зарим хэвлэлд тухайлбал, “Зууны мэдээ” сонинд Г.Жамъян гуайн бичсэн “Сэжигтэй айлчлал” гарчигтай өгүүлэл гарсан байна байсан.

Үргэлжлэл нь II нүүрт




ОНЦЛОХ МЭДЭЭ

## Хоёр хоногт 20 орчим удаа газар хөдөлжээ

Баянхонгор аймгийн Баянговь, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт энэ сарын 2-3-нд шилжих шөнө газар хөдөлжээ. Тодруулбал, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд энэ сарын 2-3-ныг шилжих хугацаанд нийтдээ 19 удаагийн чичирхийлэлтэй 1.5-3.8 магнитудын хүчтэй газар хөдөлсөн талаар аймгийн ОБГ-аас мэдээллээ.

Газар хөдлөлтийн чичирхийллийн давтамж өндөр байсан учраас иргэдийг хоргодох байр болон кемп, гэрт нүүлгэн шилжүүлж, аюулгүй байдлыг нь хангажээ. Тухайлбал, Цогтцэций суман дахь дотуур байранд амьдардаг сурагчид, Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компанийн ажилтнууд болон бусад иргэдийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлж, өндөржүүлсэн бэлэн байдал зарласан байна.

Үргэлжлэл нь II нүүрт




| | ХААН банк | | | | | Худалдаа хөгжлийн банк | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2464.00 | 2475.00 | ФУНТ | 3053.00 | 3158.00 | АМ.ДОЛЛАР | 2464.00 | 2478.00 | ФУНТ | 3051.00 | 3192.00 |
| ЕВРО | 2587.00 | 2658.00 | РУБЛЬ | 36.90 | 40.00 | ЕВРО | 2577.00 | 2700.00 | РУБЛЬ | 36.13 | 41.98 |
| ИЕН | 21.42 | 21.93 | ЮАНЬ | 357.40 | 360.40 | ИЕН | 21.26 | 22.31 | ЮАНЬ | 357.00 | 362.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

E-mail: mongoliin_medee@yahoo.com Утас: 976-70113551 Факс: 976-70113551

САЙД ЯРЬЖ БАЙНА

# Ц.МӨНХ-ОРГИЛ: УИХ-ЫН ДАРГА М.ЭНХБОЛДОД ИТГЭХ ХЭРЭГТЭЙ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тухайн нийтлэлд Засгийн газар санаатайгаар УИХ-ын даргын даалгавраар далай ламын айлчлалыг зохион байгуулаад, 10 дугаар Богдоор УИХ-ын даргын ач хүүг тодруулна гэсэн хэмээн бичсэн байсан. Иргэн хүнд, тэр тусмаа сэтгүүлч хүнд хардах, эргэлзэх эрх нь бий. Гэхдээ ямар ч тохиолдолд бариатай, тавиатай, юмны учрыг ойлгож дуугарах хэрэгтэй. Ядаж Засгийн газрын мэдэгдлүүдэд анхааралтай хандах хэрэгтэй. Засаг төр нь худлаа хэлэхгүй байлгүй дээ. Бүр болохгүй бол надаас ирээд асууж болно шүү дээ. Тэгэхээр би хариуцлагатайгаар дахиад мэдэгдэж байна. Далай ламын айлчлалд Засгийн газар оролцоогүй. Үүнд УИХ, Засгийн газар, Гадаад харилцааны яам оролцоогүй. Зөвхөн Гандан-тэгчинлэн хийдийн асуудал. Үүнд Монгол төрийн албан тушаалтнууд оролцсон эсэхийг бид мэдэхгүй. Тухайлбал, далай лам "Монгол улсын Ерөнхийлөгч намайг урилаа, баярлалаа" гээд олон түмэнд зарлачихаж байна шүү дээ. Би Ерөнхийлөгчийн өмнөөс ярьж чадахгүй. Би өөрийнхөө Ерөнхий сайд, гүйцэтгэх засаглал, УИХ-ын даргын хийж байгаа ажлыг мэдэж байгаагийн хувьд УИХ, Засгийн газар энэ айлчлалыг зохион байгуулаагүй.

**-МАН-ын дарга, УИХ-ын дарга М.Энхболдын ач хүүг 10 дугаар Богдоор тодруулсан гэх яриа нэлээд эртнээс цацагдаж эхэлсэн шүү дээ?**

-Далай ламын зааж, тодруулснаар УИХ-ын даргын ач хүүг 10 дугаар Богдоор тодруулсан юм байхгүй. Үүнийг УИХ-ын дарга хариуцлагатайгаар сарын өмнө бүлэг дээр мэдэгдсэн. Тэрбээр "Ийм гүтгэлэгт битгий автаарай. Миний ач хүү ямар нэгэн дүрээр тодроогүй, өсч торниж байгаа" гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдсэн. Тэгэхээр үүнд итгэх хэрэгтэй.

**-БНХАУ-ын талаас Гашуун Сухайт боомтоор гарч байгаа бараа бүтээгдэхүүнд хураамж нэмсэн байна. Энэ асуудал Далай ламын айчлалаас болсон уу. Эсвэл?**

-Өчигдөр /өнгөрсөн пүрэв гараг/ би энэ асуудлаар БНХАУ-ын холбогдох байгууллагаас тодруулна гэж хэлсэн. Бид тодруулга авсан. 2016 оны арваннэгдүгээр сарын 02-ны өдөр, өөрөөр хэлбэл, Далай ламын айлчлалаас өмнө ӨМӨЗО-ны Хөгжил шинэчлэлийн хорооны тогтоол гаргасан. Уг тогтоолд "Боомтын үйлчилгээний төлбөрийг нэмэгдүүлэх тухай" байсан бөгөөд энэ тогтоол нь ӨМӨЗО-ны бүх боомттой холбоотой. Тухайлбал манай Гашуун сухайт, БНХАУ-ын ганц модны боомт байрладаг ӨМӨЗО-ны Баяннуур гэж аймгийн захиргаа нь энэ тогтоолыг хэрэгжүүлэх шийдвэрийг 2016 оны арваннэгдүгээр сарын 22-ны өдөр гарсан. Ямар тогтоол гарсан бэ гэхээр өмнө нь нэг тонн нүүрнээс таван тонн нүүрснээс авдаг байсан татвараа найман юань болгосон байна. Мөн өмнө нь нэг машинаас 10 юаний төлбөр авч байгаагүй юм байна. Үүнийг шинээр нэмэгдүүлж байгаа юм билээ. Өмнө нь зэсийн нэг тонн баяжмалаас таван юанийн төлбөр авч байсныг үнийн дүнгийн 0.2 хувь болгосон байгаа юм. Өөрөөр хэлбэл, Өмнө нь огт авч байгаагүй биш авч байсан гэсэн үг. Төлбөрөө нэмэгдүүлж, ийнхүү нэмэгдүүлэх шийдвэр нь арваннэгдүгээр сарын 02-нд буюу Далай ламын айлчлалаас өмнө гарсан бөгөөд хэрэгжүүлэх тогтоол нь арваннэгдүгээр сарын 22-нд гарсан байсан. Төлбөр нэмэгдсэнтэй холбоотойгоор жилдээ Монгол Улсын ААН-үүд ойролцоогоор 12.3-12.5 сая ам.долларын нэмэлт төлбөр өгч байгаа юм байна. Энэ төлбөр хэр удаан үргэлжлэх, ямар үр дагавартай талаар, буулгах боломжтой эсэх талаар бид жич ярилцаж байгаа.

**-Далай ламын айлчлалтай холбоотойгоор БНХАУ-д хийх айчлалууд зогсоод байгаа шүү дээ. Тэгвэл энэ талаар тус улстай харилцаагаа сэргээх тухай ямар нэгэн яриа хэлэлцээр хийсэн үү?**

-Бид ярьж байгаа. Аль болох хурдан сэргээх хүсэлтэй байна. Ажлын уулзалтууд, яриа хэлэлцээрээ эхлүүлмээр байна гэдэг асуудлуудаа тавьж байгаа.

**-Дуучин Амараа ОХУ-ын Элчин сайдын яамны дипломат ажилтанд зодуулсны улмаас сэхээнд байгаа гэсэн. Танд энэ талаар мэдээлэл ирсэн үү?**

-Ямар Амараа?

**-Монголын "Хар сарнай" гээд хамтлагийн дуучин С.С.Амармандах?**

-Мэдэхгүй. Би тийм зүйл ёстой сонсоогүй юм байна. Манай хэвлэлийн төлөөлөгчтэй холбогдоод энэ талын мэдээлэл авчих уу.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

## Ж.Эрдэнэбат: Жилд 730 мянган хүн халамж хүртэж байгаа

УИХ-ын баасан гарагийн чуулганы үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Нийгмийн хааламжийн санд тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн юм. Энэхүү мэдээллээр 2016 онд хүүхдийн мөнгө олгоход зориулж 144 тэрбум төгрөг тусгасан нь эхний зургаан сард зарцуулж дууссаныг төсөвт тодотгол хийх хүрээнд үргэлжлүүлж олгосон байна. Ингэснээр энэ оныг дуустал хүүхдийн мөнгө олгох боломжтой бүрджээ. Мөн жилд 730 мянган хүн халамж хүртэж байгаа нь дөрвөн хүн тутмын нэгд халамж чиглэж буйг харуулж буй аж. Ажил хийдэг хэрнээ халамжид хамрагдах хүсэлтэй иргэд ч олон юм байна. Иймээс халамжийг зорилтот хэсэгт хүргэх тогтолцоог бий болгох, хөдөлмөрлөх чадвартай боловч халамж хүртэх сонирхолтой иргэдийг ядуурлаас гаргах олон талын арга хэмжээ хэрэгжүүлж ажиллахаар тодорхой бодлого гарган, эхнээсээ хууль эрх зүйн өөрчлөлт хийж эхэлсэн гэдгийг онцоллоо.

УИХ-ын чуулганы үдээс өмнөх хуралдаан эхлэхийн өмнө УИХ-ын гишүүд техникийн спиртэнд хордсон иргэдийн талаар Ерөнхий сайдыг мэдээлэл хийхийг хүссэн байна. Энэ талаар мөн мэдээлэл өгсөн юм. Дорнод аймгийн Халх гол суманд үйл ажиллагаа явуулж байгаа "Петро чайна дайчин тамсаг" компанид ажиллаж байсан иргэд шингэн зүйлийг ууснаас хордсон гэдэг эхний мэдээлэл орон нутгаас Улаанбаатар хотод 2016 оны арваннэгдүгээр сарын 26-ний 18.00 цагт ирсэн байна. Энэхүү мэдээллийн дагуу Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комисс яаралтай хуралдаж, хоёр ч ажлын хэсэг байгуулж ажилласан. Улаанбаатар хотоос хоёр эмч, хоёр сувилагч илгээж, эрүүл мэндийн шаардлагатай тусламжийг үзүүлсэн. Хордлогод орсон иргэдийн амь насыг аврах чиглэлээр шуурхай ажилласан төдийгүй, шаардлагатай тоног төхөөрөмжийг Дорнод аймаг руу авч явснаар цаг алдалгүй шаардлагатай эмчилгээг хийж чаджээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Парламентын сэтгүүлчид номын дуу сонслоо

УИХ-ын Тамгын газар, Монголын парламентын сэтгүүлчдийн холбоо хамтран "Улсын Их Хурлын үйл ажиллагаа парламентын сэтгүүлчид" сэдэвт сургалтыг зохион байгуулав. Уламжлал болгон явуулдаг уг сургалтад УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон, УИХ дахь МАН-ын бүлгийн ажлын албаны дарга Н.Энхтайван, АН-ын бүлгийн ажлын албаны дарга Д.Золжаргал, УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга С.Батбаатар нар оролцсон юм. Хэвлэл мэдээллийн байгууллагын парламентын сэтгүүлчдийн төлөөлөл оролцсон уг сургалтад УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга С.Батбаатар "УИХ-ын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах талаар Тамгын газраас авч хэрэгжүүлж байгаа ажлын тухай" мэдээлэл өглөө. Түүнчлэн Парламентын сэтгүүлчдийн холбооны тэргүүн Ж.Алтангэрэл "Парламентын сэтгүүлчдийн холбоо, парламентын сэтгүүлчид", Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Цогтсайхан "УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын хуралдааны үед хэвлэл мэдээллийн ажилтнуудын анхаарах зарим асуудал", Төрийн ордны хамгаалалтын албаны дарга, хурандаа Х.Ариунболд "Төрийн хамгаалалт, үйлчилгээний журам, хэвлэл мэдээллийн ажилтнуудын анхаарах зарим асуудал", Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ахлах референт Ш.Содномжамц "УИХ-ын үйл ажиллагааг сурвалжлан мэдээлэхэд хэвлэл мэдээллийн ажилтнуудын дагаж мөрдөх журам", Мэдээлэл, хяналт шинжилгээ, үйлчилгээний хэлтсийн референт Ц.Болормаа "Гадаадын парламентын сурвалжлагчдынүйлажиллагааны жишиг" сэдвээр тус тус мэдээлэл хийсэн юм. Мэдээлэлтэй холбогдуулж сэтгүүлч, сурвалж-лагчид сонирхсон асуултаа асуухын зэрэгцээ тэдний өмнө тулгарч байгаа асуудал, хүндрэл бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар санал бодлоо солилцлоо.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс:**
**976-70113551**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ДУУЛИАН

## Сүхбаатар дүүргийн МАН-ын удирдлагууд эмэгтэй хүн зодож танхайрчээ



Намын улс төрийн ажилтан К.Олимпиад



Сү.Батболдын бие төлөөлөгч, "Чингис" зочид буудлын хамгаалалтын албаны дарга Мөнхбаатар

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн МАН-ын хорооны 62 дугаар үүрийн хурлын үеэр намын улс төрийн ажилтан К.Олимпиад гэгч согтуу эр шаардлага тавьсан эмэгтэйг зодож, танхайрсан гэх мэдээлэл ирлээ. Тодруулбал, Сүхбаатар дүүргийн МАН-ын хороо өчигдөр 11:00 цагийн орчимд намын дүрмийн бус хурал зарлаж, дүүргийн хэмжээнд байдаг 20 үүрээ хуралдуулжээ. Энэ үеэр 62 дугаар үүрийн хуралд оролцож байсан гишүүд "Дүрмийн хурал хийгээч" гэдэг шаардлага тавьсан аж. Гэвч энэхүү шаардлагыг тус хуралд оролцож байсан Сүхбаатар дүүргийн МАН-ын хорооны дэд дарга О.Мөнгөншагай, Б.Ганбаатар нарын хүмүүс хүлээж авалгүй, шаардлага тавьсан эмэгтэйг хэл амаар доромжилжээ. Түүнчлэн хууль бус хурал зарлаж, өөрийн тойрон хүрээлэгчдээр хурлын ирцээ бүрдүүлж, өөрсдийн гэх тодотголтой хүнээр намын дарга болгоно гэж хүч түрэмгийлж, зохион байгуулалтайгаар хүмүүсийг машинаар зөөж авчирч нууцаар хуралдсан нөхдүүд шаардлага тавьсан эмэгтэйг зодож танхайрсан аж. Эх сурвалжийн мэдээлж буйгаар шаардлага тавьсан эмэгтэйн бие тааруу байгаа бөгөөд зодсон хүнийх нь согтолтыг хэмжүүлэхэд 1.6 хувьтай гарсан байна. Дашрамд дурьдахад, Сүхбаатар дүүргийн МАН-ын хорооны дэд дарга Мөнгөншагай нь УИХ-ын гишүүн Сү.Батболдын хамаатан гэнэ. Мөн дээрх үйл явдлын үеэр Сү.Батболдын бие төлөөлөгч, "Чингис" зочид буудлын хамгаалалтын албаны дарга ажилтай Мөнхбаатар гэдэг залуу ч оролцоод амжсан гэнэ шүү.

ШАР МЭДЭЭ

## О.Баасанхүү "сэргэлэнтэв"

УИХ-ын чуулганы хуралдааны үеэр гишүүдийн дунд зарчмын зөрүүтэй саналаас болж нэлээд маргаан үүсээд авсан. Эрх баригчдын маргааныг ашиглаад УИХ-ын гишүүн О.Баасанхүү МАН-ын гишүүдийг намдаа уриад амжсан юм. Тэрбээр "МАН-ынхныг 65-уулаа болгосон нь та бүхнийг дотроо эвтэй найртай, хоорондоо хэрэлдэлгүй ажлаа явуулаарай гэж сонгосон гэж бодож байна. Хэрвээ та бүхэн хоорондоо ойлголцож чадахгүй байгаа бол манай намд ороорой. Манай нам та бүхнийг хүлээж авахад бэлэн шүү" хэмээн зөвлөөд авсан. Тиймээс аль хэдийнэ дотроо хөлөө жийлцээд эхэлсэн МАН-ынхан намаасаа гарвал тосоод авах нам бэлхэн байгаа бололтой.

ОНЦЛОХ МЭДЭЭ

## Хоёр хоногт 20 орчим удаа газар хөдөлжээ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Харин Баянхонгор аймгийн Баянговь сумын төвөөс баруун хойд зүгт 20 км-т арванхоёрдугаар сарын 03-ны өдрийн 06:09:23 цагт 4.6 магнитудын хүчтэй газар хөдлөлт болсон тухай мэдээллийг ООГСХ-оос цахим шуудангаар ирүүлсэн байна. Газар хөдлөлийн улмаас чичирхийлэл мэдрэгдсэн ч хохирол учраагүй гэсэн мэдээлэлтэй байна. Дашрамд дурьдахад, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн үйл ажиллагаатай танилцах үеэрээ "Өнгөрсөн жилүүдэд ҮАБЗ-ийн хүрээнд бид гамшгийн асуудлыг нэлээд авч ярилцсан. Санаа зовоож байгаа нэг гамшиг бол газар хөдлөлтийн гамшиг юм. Мянгаад жилийн өмнө, Улаанбаатарын энэ бүсэд газар хөдөлж байсан гэдэг дүгнэлт байдаг. Тэр мянгаад жил нь одоо болчихсон. Дээр нь Улаанбаатарыг тойрсон газар хөдлөлтийн маш хүчтэй хагарлууд бий. Хагарлууд хоорондоо уулзах ийм үйл явц ойрхон болж байгаа. Нэг үгээр хэлбэл, ойрын маш богинохон хугацаанд




Улаанбаатар хотод маш хүчтэй газар хөдлөлт болох хандлага байна гэдгийг гадаад, дотоодын судлаачид, эрдэмтэд гаргаж ирж, үргэлж анхааруулж байна" гэсэн билээ. Тиймээс газар хөдлөлт эрчимжиж, нийслэлд ч газар хөдлөлт болж болзошгүй байгаа юм.

# ҮЗЭЛ БОДОЛ



## УБЦТС ТӨХК-ийг бараа судлаачаар удирдуулсны цаана ХУВЬЧЛАХ хуйвалдаан нуугдаж байна уу

Н.ПУНЦАГБОЛД

МАН сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж, Засгийн газраа байгуулсан. Засаг солигдох болгонд ёс юм шиг дагадаг нэг зүйл байдаг нь халаа, сэлгээ. Тэр ч жам ёсоор энэ намаржин хурган дарга нар солигдож, тэд нь багаа бүрдүүлж байгаа нэрийдлээр байгууллагуудыг самарсаар л байна. За тэр яам, тамгын газар ч яах вэ, дүүрч. Нэг сайд очоод, хүмүүсээ хольж, солио л биз. Харин шат шатандаа мэргэжлийн хүмүүс ажиллах шаардлагатай зарим нэг байгууллагын даргыг сольчихмооргүй байгаа юм. Гэтэл эрхэм эрх баригчид, эвэртэн туурттнууд албан тушаал өгөх хэрэгтэй гэж үзсэн хүн бүрээ хаана ч хамаагүй аваачиж “зоож” байна. Тухайлбал, Улаанбаатар хотын 1.3 сая иргэний эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах ёстой газар, улсын онцгой объект гэж хэлж болох УБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлаар Д.Баярсайхан гэдэг нөхрийг томилсон байгаа юм. Тэрбээр өнгөрсөн есдүгээр сарын сүүлчээр ажлаа хүлээж авсан юм билээ. Түүнээс хойш халаа сэлгээ л хийж суугаа тухай эх сурвалжууд мэдээлж байна. Ер нь тэрбээр одоо энэ байгууллагад ажиллаж байгаа бүхий л чадвартай, ажилдаа гаршсан, олон жил ажилласан хүмүүсийг толгой дараалан “намнах” зорилготой гэдгээ өөрөө бараг ил тодоор зарлаж эхэлсэн юм байх аа. Одоогоор эрчим хүчний салбарт цахилгаанчнаас эхлээд инженер, дарга болтлоо 15-20 жил ажилласан цөөнгүй хүмүүсийг халж, оронд нь 20 гаруй хүн ажилд авчихаад байгаа байгаа гэнэ. Тэр дунд нь улсад 2, 3-хан жил ажилласан, цүнх барихаас өөрийг хийгээгүй “нялх Сэнгүм”-үүдээс авахуулаад тэс хөндлөн мэргэжилтэй нөхдүүд ч цөөнгүй байгаа бололтой. УБЦТС ТӨХК-ийг ийн самарч байгаа нь эрхэм захиралтан Д.Баярсайхан өөрөө мэргэжлийн биш хүн учраас тэр гэнэ. Энэ нь түүний УБЦТС ТӨХК-ийн захирлаар томилогдохдоо бөглөсөн төрийн албан хаагчийн анкетыг харахад л мэдэгдэнэ. Мань хүн гэр бүл, садан төрлийн байдал, оршин суугаа газрын хаяг энэ тэрээ бол сайхан л бөглөчихсөн байна билээ. Харин “Боловсролын талаархи мэдээлэл”-ээс эхлээд л эвгүйтэнэ дээ. Тэрбээр 1974-1984 оны хооронд Ховд аймгийн нэгдүгээр 10 жилийн сургуулийг төгссөн байгаа юм. Улмаар 1999 он хүртэл 15 жилийн турш хаагуур ч юм, юу ч юм хийж явж байснаа гэнэт л СЭЗДС-д элсч ороод, хоёрхон жил сураад 2001 онд төгсчихөж. Тэгэхдээ бараа судлаач, эдийн засагч мэргэжлээр. Өмнө нь ямар нэгэн их, дээд сургууль төгсөөгүй хүн яаж яваад бүхэл бүтэн СЭЗДС-ийг хоёр жил хагасын дотор төгссөн нь бас сонирхолтой. Улмаар Удирдлагын академид 2003-2005 оны хооронд суралцаж, Удирдахуйн ухааны магистр цолтой болжээ. Цаашлаад хаана, ямар байгууллагад, хэдээс хэдэн оны хооронд ажиллаж байсан талаар мэдээлэл огт байхгүй. Анкет бөглөснөөс нь харахад, энэ хүн улсад ганц ч жил ажиллаагүй байгаа юм. Тэгээд дээрээс нь цахилгааны талаар А ч байхгүй нөхөр. Гэтэл бүхэл бүтэн 1800 ажилтантай УБЦТС компанийн гүйцэтгэх захирлаар ирчихээд, хамаг л чадвартай, сайн ажилласнаас нь түүж халаад сууж байгаа чинь одоо ариун явдал мөн үү. Сураг сонсох нь ээ, мань бараа судлаач чемодан дүүрэн анкеттай ирсэн юм байх аа. Өөрийнх нь ажилд авах ёстой хүмүүсийнх нь анкет юм байлгүй дээ. Тэгээд л ватт, вольтыг ч ялгахгүй хүмүүсийг авчирч ажилд томилоод байгаа гэнэ. Угаасаа мэргэжлийн бус хүн өөрөөсөө чадвар муутай, юм мэдэхгүй нөхдүүдийг л ажилд авч таарна шүү дээ. Хэрвээ энэ байдлаараа нөхцөл байдал үргэлжилбэл Улаанбаатар хотод байгаа 300 мянган айл өрхийн цахилгаан эрчим хүч доголдох, нийслэл харанхуйлахад хүрвэл яана. Дээрээс нь энэ хүн ААД, ТАД-ийн талаар юу ч мэдэхгүй. Энэ бол УБЦТС ТӨХК-д ажиллаж байгаа хүн бүрийн аюулгүй байдал, амь настай нь хамаатай асуудал. Гэтэл тэр хүн аюулгүй ажиллагаа гэдгийг өөрийнхөө гадарладаг экспорт, импортоосоо ялгаж чадахгүй л сууж байгаа шүү дээ. Мэргэжлийн бус хүний балгаас болоод нэг л өдөр Улаанбаатар хотын цахилгаан доголдоход хүрвэл яана. Энэ байгууллагын ажилчдын аюулгүй байдал алдагдвал яах болж байна аа. Ялсан нам дарга, албан тушаалтнаа сольж болно оо. Ёстой лаагаа иднэ үү, лууваңгаа иднэ үү дурын асуудал. Гэхдээ Улаанбаатар хотыг найдвартай эрчим хүчээр хангах чухал үүрэг бүхий энэ газрын захирлаар зүгээр нэг бараа судлаач мэргэжилтэй нөхрийг аваачаад тавьчихдаг нь зүйд нийцэж байна уу даа, энэ чинь. Гэтэл мань нөхөр өөрийгөө “Намайг ТӨХ-ноос томилсон” гээд л даналзаад байгаа талаар эх сурвалжууд хэлж байгаа юм.

Мөн ажлаа аваад халаа сэлгээ хийж, хаа хамаагүй хүмүүс авчирч албан тушаалд томилохын хажуугаар байгууллагын мөнгөөр туйлж эхэлсэн гэнэ ээ. Засгийн газар “бүсээ чангалах” талаар ярьж, эдийн засаг хэцүүхэн байгааг хэлж, салбар бүрт хэмнэх гэж ядаж байхад мань хүн байшин дотор байшин барьж, өрөө тасалгаануудыг засч, зүгээр байгаа угаалтууруудыг сольсон шиг л “тоглож” байгаа гэнэ. Энэ мэт мэргэжлийн биш, бодлогогүй үйлдлүүдээс нь болоод өнгөрсөн жилүүдэд ашигтай ажиллаж байсан УБЦТС ТӨХК-ийн бүх үзүүлэлтүүд сүүлийн үед доголдоод эхэлсэн сураг байна. Үүнээс үзвэл ашигтай, хэвийн ажиллаж байгаа байгууллагын даргаар мэргэжлийн бус хүнийг томилж, байдлыг дордуулах гэсэн башир арга юм биш биз гэж хардахаас өөр арга алга. Угаасаа ирэх жил цөөнгүй хэдэн газрыг хувьчлахаар болоод байгаа. Тэр дунд УБЦТС ТӨХК багтаагүй л дээ. Ашигтай, маш сайн ажиллаж байгаа болохоор хувьчилж болохгүй шүү дээ. Тийм болохоор хэвийн ажиллагааг нь алдагдуулж, өр ширэнд баригдуулж, улмаар хувьчлахаас өөр аргагүй боллоо гээд л хэн нэгэн нь авах гэсэн башир санаа байхыг үгүй гэх газар алга. Ерөөсөө төрийн ашигтай компаниудыг үймүүлж, мэргэжлийн бус хүнээр удирдуулж, эцэст нь хувьчилдаг жишээ хаа сайгүй л байна. Ер нь бол Д.Баярсайхан гэгч нөхөр УИХ-ын гишүүн Б.Батзоригийг Баянзүрх дүүргийн Засаг даргаар ажиллаж байхдаа барьж, хүүхдийн эндэгдлийг бууруулсан банхарын хөшөөг “урласан” хүн гэсэн яриа ч байгаа юм гэсэн. Өнөөдрийг хүртэл барилга угсралтын нэг компанитай л байсан бизнесмэн юмдагуу даа. Улмаар эрхэм гишүүний “татаас”-аар УБЦТС ТӨХК-д очсон ч байж болох. Хөшөө барих, цахилгаан түгээх хоёр уг нь арай л өөр юмсан даа. Хэрвээ энэ байгууллагыг “будаа” болгож, хувьчлах гэж санаархсан л биш юм бол бараа судлаачаас арай өөр хүн даргаар нь тавьсан дээр байлгүй дээ, эрх баригчид аа.

Дугаарын 60 мөр

## Залбирч ч сураагүй байж шашин шүтнэ гэж байх уу

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Алгаа хавсрах ёстой гэвэл хаанаа барих юм, нүүрний урд уу, цээжин дээр үү. Гэх мэтээс авахуулаад өнөөдөр монголчууд яаж залбирахаа ч мэддэггүй. Уг нь бурхны шашин гэдэг агуу том философи шүү дээ. Хамгийн анх үүссэн ч гэж хэлж болохоор энэ том шашинд ядаж мөргөх, сүсэглэх дэг жаяг гэж байгаа нь ойлгомжтой. Гэтэл манайхан түүнийгээ ч мэдэхгүй, зүгээр л мухраар шүтээд байгаа юм. Энэ маягаараа хэдэн жилийн дараа Монголд бурхны шашин шүтдэг хүн үлдэх үү гэдэг асуулт ч гарч ирнэ. Хэдэн жил гэхээр ойрын 10, 20 жилдээ биш л дээ. Яваандаа гэж байгаа хэрэг. Ядаж байхад манай сүм, хийдийн лам нар зүгээр л мөнгө олохыг бодохоос шашнаа сурталчилж, зөв ойлголт өгч, ядаж яаж мөргөх, сүсэглэх ёстойг ч заагаад, хэлээд өгдөггүй шүү дээ. Гэтэл Христын шашны сүм хийдүүд яаж байна. Байнга хурал, цуглаан хийж, хүнийг ухуулж, сэнхрүүлж, Ертөнцийн эзэн гэж үнэхээр байдаг гэж бат итгэтэл толгойд нь суулгаж өгч байна. Тэгэхдээ ухуулах, сурталчлах, бүр дуу хуураар хүртэл сэтгэлд нь суулгана. Бүх дэг жаягаас авахуулаад шаардлагатай бүгдийг зааж өгч байгаа юм. Дээрээс нь мөнгө санхүү, эд зүйл гээд татахгүй юм алга. Тиймдээ ч манайхан ертөнцийн эзэнд бат итгэж, сүүлдээ “Аав аа, намайг ашиглаач” гэж уйлж, бархирч байх вэ дээ. Нэг талаараа балай юм шиг болов ч энэ чинь шүтэж чадаж байна гэсэн үг. Харин манайхан шарын шашнаа ингэтэл шүтэж чадаж байгаа бил үү. Зөв шүтэж, бишрч чадвал мэдээж үр дүнгээ өгнө. Манай ард түмэн сэжгээр өвдөж, сүжгээр эдгэдэг гэж зүгээр ч нэг хэлчихээгүй юм шүү. Энэ чинь сэтгэл дотроо сүсэглэж, эдгэнэ гэдэг бодлыг тархиндаа бат суулгаж өгснөөр үр дүнд хүрнэ гэдгийг л хэлээд байгаа хэрэг. Харин манайхан болохоор хийморийн сан тавихаар л хийморь нь сэргээд, ажил нь бүтнэ гэж муйхраар санаад, зөв залбирах, зөв шүтэх гэдгээ ч огоорчихсон. Хамгийн гол нь сэтгэлээ ариусгаж, сөрөг бодлуудаа эерэг эрчмээр сольж, түүнийхээ хүчээр сайн сайханд хүрнэ гэдгийг ч ухаарахгүй л байгаа юм. Бурхны шашин гэдэг өнөөдөр нэг ламаар ном уншуулаад, өнөөх нь хурлаа хурж байхдаа ухаалаг утсаа оролдоод, орой уулзах хүүхнийхээ тухай завсар хооронд нь ярилцаад байж байхад аяндаа сайхан болчихно гэж мухраар шүтэхээс арай л өөр байх. Угтаа бол энэ лам ном уншчихлаа, одоо л миний юм бүхэн сэтгэчлэн бүтнэ гэж өөртөө эерэг бодол үүсгэхэд л бурхны шашны гол нөлөө байх ёстой болов уу гэж бодох юм. Гэтэл хэдэн ном уншуулахын төлөө тогтоосон тарифаар мөнгөө төлөөд, дараа нь өгсөн мөнгөө л бодоод явбал хэцүү л дээ. Тиймдээ ч хүмүүс залбирахдаа хүртэл сэтгэл гаргахгүй, алгаа хавсрах уу, гараа салаавчлах уу гэдгээ ч мэдэхгүй л явсаар байгаа юм. Үндсэндээ зүгээр л хэн нэгнийг дагаж лам дээр очдог, гандан ордог хүмүүс дүүрчихжээ, энэ улсад. Шүтэж чадахгүй, ядаж залбирч ч мэдэхгүй бол өөртөө итгэх нь арай дээр байх даа.

ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛЫН ХӨТӨЛБӨР
Хуримтлалыг зуршил болгоё!
39400 ХАРИЛЦАГЧ НЭГДЭЭД БАЙНА
www.HURIMTLAL.com
хаягаар дансаа нээлгээрэй

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЮУНЫ



–Хилийн зурвас дээр

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

**Хуулийн хэлэлцүүлгийн шатанд:**



**УИХ-ын гишүүн Л.Мөнхбаатар:** Хилчдийн эрх зүйн байдлыг дээшлүүлсэн, хилийн шалгантай холбоотой хуулийн дэмжиж байгаа. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа бол улсын хил хамгаалахтай салшгүй холбоотой асуудал. Цаашдаа Гадаадын иргэн харьяатын байгууллагыг яах вэ. Хилийн шалган нь Хил хамгаалах байгууллагад шилжвэл энэ байгууллага цөөхөн хэдэн чиг үүрэгтэй болох гээд байна.



**Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт:** Хилийн тухай хуулиар шалган нэвтрүүлэх байгууллагыг хил хамгаалах байгууллагад оруулж байгаа. Гадаадын иргэний харьяатын байгууллага олон хууль тогтоомжоор хэрэгжүүлдэг чиг үүрэгтэй. Тиймээс энэ байгууллагыг нь хэвээр нь үлдээж, чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэж үзэж байна.



**УИХ-ын гишүүн Х.Баделхан:** Өмнө хилийн шалган бүртгэх хэсэг хилийн цэрэгт харьялагддаг байсан. Өнгөрсөн дөрвөн жилд яагаад хилийн шалган нэвтрэх хэсгийг гадаадын иргэн харьятын байгууллагад харьялуулсан юм бэ. Ер нь олон улсын хэмжээнд хилийн шалган нэвтрэх хэсэг ямар газартаа харьялагддаг вэ. Энэ талаар судалж үзсэн үү. Мөн хилийн зурвасыг 100 метрээр ойртуулна гэж байна. Ямар үндэслэлээр татаж байгаа юм. Өмнөх хуульд 100 метрээс дотогш нэвтрэхээр бол зөвшөөрөл авдаг байсан. Мөн хилийн зурваст ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газар бий юу.



**Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт:** Манай улсад нийт 46 боомт байна. Уг боомтуудаар жилд дөрвөн дөрвөн сая 300 мянган иргэн, нэг сая 600 мянган тээврийн хэрсэгсэл, нэг сая ачааны болон нийтийн галт тэрэг зорчдог. Бид олон улсын төвшинд судалгаа хийсэн. Нийт 30 гаруй улсыг судаллаа. Судалгаанд орсон 30 улсын 15 нь хилийн шалган нэвтрэх хэсгээ хил хамгаалах байгууллагад харьялуулсан байсан. 10 гаруй нь хилийн цагдаад, үлдсэн нь гадаадын иргэн харьятын байгуулагад харьялагдаж байсан. Үүнээс харахад, энэ олон улсын төвшинд нийцэж байгаа юм. Ихэнх улс орнууд хил хамгаалах байгууллагадаа харьялуулсан байна.



**УИХ-ын гишүүн Х.Баделхан:** Хилийн тухай хуульд заасны дагуу хилийн зурваст үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд бий юу. Хилийн зурвасыг багасгаснаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага нь багасгах уу.



**ХилхамгаалахерөнхийгазрындаргаЦ.Сэргэлэн:** Яг өнөөдрийн байдлаар хилийн зурваст 81 аж ахуй нэгж банк, гаалийн зуучлал, газар тариалан гэх мэт үйл ажиллагаа явуулдаг. Мөн ашигт малтмалын чиглэлээр есөн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Хил хамгаалах байгууллагаас тодорхой зөвшөөрлөө аваад явж байгаа.



**УИХ-ын гишүүн Х.Болорчулуун:** Өнгөрсөн дөрвөн жилд Хил хамгаалах хуульд өөрчлөлт ороод Хилийн цэргийг эмнэлэггүй, тагнуулгүй болгосон. Энэ бүхэн хил хамгаалах байгууллагын чадамжийг бууруулсан. Энэ хуулийн нэг онцлог сайн давуу тал нь шалганыг эргээд хилийн цэрэг рүү ирүүлж байгаа явдал гэж үзэж байгаа. Мөн уг хуульд хилийн зурвасыг 15 км болгоод бүсгүй болгож байгаа юм байна. Гэхдээ энэ хилийн зурвасыг бүс дээр газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэхийг хуулиар хязгаарлаж, зөвхөн хил хамгаалалтын зориулалтаар ашиглах асуудлыг баталгаажуулах нь зүйтэй гэж оруулсан байна. Үүнийг шууд баталгаажуулна гээд заачихвал зүгээр байх. Зүйтэй гэсэн санаа байдлаар оруулчихсан байх юм. Түүнчлэн эзэмшүүлэх, өмчлүүлэхийг хориглох гэж байгаа юм байна. Тэгвэл ашиглуулахыг яах юм бэ. Ер нь ашиглуулах, эзэмшүүлэх гэдэг чинь агаар нэг зүйл биш үү. Сүүлийн үед хилийн хамгаалалтыг сулруулсан асуудал нь хилийн загонтой ойрхон ашигт малтмалын үйл ажиллагаагаа эрхэлж байгаа явдал. Тухайлбал, Дэгээ голын заставын цаана төмрийн хүдэр олборлож байна. Халх голын Улаан худаг гээд заставын хажууд буюу хилийн шугамаас хоёр км зайд газрын тос олборлож байгаа. Энэ нь газрын хэвлийн хил алдагдах байдал байх биш үү гэсэн болгоомжлол төрж байна. Уг асуудалд ямар бодолтой байдаг вэ. Түүнчлэн хил хамгаалах байгууллагын туслах хүчин буюу иргэдийн эрх, үүргийг заасан байна. Тэгвэл эргүүлээд болзошгүй аюул гамшиг ослын үед хилчид иргэддээ яаж туслах вэ гэдгийг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Учир нь өнгөрсөн хавар тавдугаар сард Буйр дээр дөрвөн хүн осолдсон. Тухайн үед хоёр хүнийг нь аврах боломжтой байсан. Гэтэл нэг хүн нь мөсөн дээрээ нөгөө хүн нь мөснөөс мөс дамжиж байгаад, нас барсан. Хэрвээ хилийн цэргийнхэн санаа тавьсан бол тусламж боломж байсан. Тиймээс харилцан туслалцах уялдааг тусгах хэрэгтэй.



**Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт:** Хилийн зурваст газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлын тухайд 2014 онд хилийн шалган нэвтрүүлэх алба Гадаадын иргэн харьятын албад шилжсэнтэй холбоотойгоор Боомтын тухай хууль гээд тусдаа хууль гарсан. Уг хууль хилийн зурваст буюу хилийн боомт дээр газар эзэмшүүлэх, ашиглуулж болно гээз заачихсан юм билээ. Өөрөөр хэлбэл, хилийн боомт болоод хилийн зурвас дээр Монгол Улсын болоод гадны аж ахуйн нэгж байгууллага газар эзэмших, ашиглаж болохоор заасан байгаа. Энэ нь Монгол Улсын хил халдашгүй дархан байх Үндсэн хуулийн заалт зөрчигдчихсөн байсан. Үүнийг бид энэ удаад засч, залруулж байгаа. Хилийн зурвас дээр газар эзэмшүүлэх асуудал байхгүй. Харин зайшгүй тохиолдолд газар ашиглуулах асуудал байгаа. Учир нь тэнд гааль, мэргэжлийн хяналт, татвар, банк, холбоо гээд үйлчилгээнүүд явагдаж байгаа. Тиймээс тодорхой хэмжээнд газрыг гэрээгээр ашиглуулахаар заасан. Шалган нэврүүлэхтэй холбоотой олон асуудал байгаа. Бүхэл бүтэн вагон шалгахгүй гаргаж байсан тохиолдол ч байгаа. Вагонд хүн хавчуулагдаад хүн нас барсан, хөлдөөгчин дотор хүн оруулж ирж байхад холбогдох байгууллагууд нь мэдэхгүй оруулж ирж байсан гээд олон асуудал гарч байсан. Тиймээс хил хамгаалах байгууллагын харьянд шалган нэвтрүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулах, хилийн хяналтыг хариуцлагыг давхар сайжруулах үүднээс энэ асуудлыг хуульд оруулж ирж байгаа. Хилийн туслах хүчний талаар энэ хуульд тодорхой тусгасан. Өмнө нь ийм тодорхой тусгаж өгсөн зүйл байгаагүй. Өөрөөр хэлбэл, улсын хил хамгаалалтад туслах хүчний байгууллагууд болоод иргэдийн эрх, үүргийг тодорхой тусгаж өгсөн.



**Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн:** Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны дүрэм нь маш нууцын зэрэглэлтэйгээр батлагддаг. Хил хамгаалалтын дүрэм дээр хлийн манаа ямар үүрэг гүйцэтгэх вэ гэдэг нь маш тодорхой байдаг. Үүнд хил орчмын нутаг дэвсгэрт гарсан гал түймэр болоод бусад аюул осол, хил давж ирсэн түймэр зэрэгт шууд авран туслах ажил хийхээр заасан байгаа. Тиймээс ч манай хилчид өнөөдрийг хүртэл хил орчмын нутаг дэвсгэр дээр бүх асуудалд туслаж, дэмжээд явж байгаа. Энэ дүрмээрээ зохицуулагддаг асуудал. Харин энэ хууль шинэчлэгдсэний дараа тэрхүү дүрэм шинэчлэгдэх асуудал яригдах байх. Тэр үед нь энэ асуудлыг өшөө тодорхой болгож болно.



**УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар:** Энэ хуулийг үндсэнд дэмжиж байгаа. Гэхдээ албан үүргээ гүйцэтгэхдээ иргэн, аж ахуйн нэгж байгууллагын баримт бичгийг шалгах, хил зөрчигчдийг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл болоод тээвэрлэж байгаа бараанд үзлэг хийнэ. Манаагаар дагалдуулна гэж байна. Мөн нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл болоод бараанд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийнэ гээд заачихсан байна. Тэгэхээр бараанд гэдэг үг нь гааль, мэргэжлийн хяналт шалгана дээр нь дахиад хил шалгана гэсэн үг. Энэ нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид хүнд суртал гэдэг нь улам бий болно. Ер нь бараанд заавал шалгалт хийх ямар ч үндэслэлгүй биз дээ. Энэ үгээ аваарай Хууль зүйн сайд аа. Учир нь хүнд суртал их байх тусмаа бизнес эрхлэх хүн цөөрч бүгд хилийн цэрэгт ажилд орно. Эсвэл бүгд төрд ажилд орохыг хүснэ. Мөн Гадаадын иргэн харьятын эрхлэх газрын хувьд арай өөр саналтай байна. Юу гэхээр гадаадын хүмүүсийг нь Гадаадын иргэн харьятын эрхлэх газар нь шалгаад, дотоодын иргэдээ хилийн цэрэг нь шалгаад боломжтой. Гадны улсуудад ийм тогтолцоо байдаг.



**Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт:** Боомтын нутаг дэвсгэр дээр хилийн хяналтын байгууллагууд үйл ажиллагаа явуулна. Үүнд орох, гарах урсгал дээр тодорхой чиг үүрэгтэйгээр, дарааллуудыг тогтоосон Засгийн газрын тогтоол байдаг. Үүний дагуу хил хамгаалах байгууллагууд ажилладаг. Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд хяналт тавихгүй бол өнөөдөр гааль, мэргэжлийн хяналтаар хянуулахгүй хилийн зуравсаас гарах тохиолдол олон гардаг. Энэ мэт асуудлаас урьдчилан сэргийлэх зорилгоор бараанд хяналт тавих ёстой гэсэн үг оруулж байгаа. Гэхдээ энэ бараанд үзлэг шалгалт хийнэ гэсэн үг биш. Гаалийн болоод мэргэжлийн хяналтын байгууллагатай адилхан чиг үүрэг гүйцэтгэхгүй. Ганцхан холбогдох гаалийн байгууллагаар хянуулсан, шагуулсан эсэхийг шалгах юм.



**Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн:** Энэ бол боомт дээрх үйл ажиллагаа биш. Хуульд албан үүрэг гүйцэтгэхдээ гэж заасан байгаа. Хилийн эрэл хийгээд боомтын биш газар, хил зөрчигчийг эрүүлэх зорилгоор олон үйл ажиллгаанууд явагддаг. Өөрөөр хэлбэл, тээврийн хэрэгсэлд нуусан, ачаа барааны дунд орчихсон эсэхийг шалгадаг. Харин манаагаар дагалдуулна гэдэг бол өртөөн дээр б ү х хилийн хяналтын байгууллагууд шалгаад дууссан галт тэрэг улсын хилийн шугам давах хүртэл олон км байдаг. Энэ хооронд тухайн тээврийн хэрэгсэлд хил зөрчигч ороод нуугдах буюу бусад ямар нэгэн хэлбэрээр тухайн тээврийн хэрэгсэлд юм нуусан эсэхийг мэдэх зорилгоор хилийн манааны үйл ажиллагаа байдаг үүний хэлж байгаа юм.



**УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар:** Ер нь хилийн цэрэг бараанд шалгалт хийлдэг байсан. Энд сууж байгаа хүмүүс бараг мэдэхгүй байх. Би хилээр бараа оруулаад ирдэг. Гэтэл хоёр хилийн цэрэг орж ирээд, авч яваа барааныхаа улыг гарга гээд бүхэл бүтэн гурван өдөр зогсоодог тохиолдол зөндөө байгаа. Гэтэл та нар өөрөөр талбарлаад байна. Гэтэл амьдрал дээр тэс өөр байдаг.



**Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн:** Ажлын хэсэг дээр энэ асуудалд сайн ойлголцолд хүрэх байх. Би энэ “бараанд” гэдэг үгийг авч хаях эрх мэдэлтэй хүн биш.



**УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж:** УИХ-ын чуулган дээр зарим гишүүд баримт нотолгоогүй зүйл ярьж байна. Л.Мөнхбаатар гишүүн вагон шалгаагүй гаргасан гээд байх юм. Ер нь нотолгоотой ярих хэрэгтэй. Хилийн шалган нэвирүүлэх чиг үүрэг 2014 оны дөрөвдүгээр сарын 01-ны өдрөөс Гадаадын иргэн харьятын асуудал эрхэлсэн газарт ирсэн. Гэтэл вагон шалгаагүй үйл ажиллагаа 2013 оны наймдугаар сард болсон. Өөрөөр хэлбэл, нэг ахмад цолтой нөхөр хариуцлагагүй ажилласан гэсэн үг. Тэгэхээр хэлж байгаа үнүүддээ жаахан хариуцлагатай байх ёстой гэдгийг сануулмаар байна. Өнөөдөр хэрэгжиж байгаа Хилийн тухай хуулийн 33.1-т шаардлагатай үед иргэний баримт бичгийг шалгах, хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл болоод тээвэрлэж байгаа бараанд үзлэг хийнэ гэж заасан байдаг. Мөн 1.4-т улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл, бараанд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийж болно гэсэн байна. Өөрөөр хэлбэл, Хил хамгаалах байгууллагад бүх тээврийн хэрэгсэлд үзлэг хийх эрх нь өнгөрсөн хугацаанд бүрэн байсан гэсэн үг. Тиймээс бүх асуудлыг Гадаадын иргэн харьятын асуудал эрхэлсэн газарт наагаад хилийнхэн асуудлаас сугарч үлдэнэ гэж бодож байгаа бол эндүүрэл шүү. С.Бямбацогт сайдад хандаж хэлэхэд, салбар хариуцсан сайд нь өөрийн харьяаны байгууллагын нэгийг гэрийнхээ хойморт суулгаад, нөгөөг нь цаанаа байж бай гэх маягаар энэхүү хуулийн төслийг оруулж ирсэн байна. Өөрөөр хэлбэл, хилийн хяналтын байгууллагад Гадаадын иргэн харьятын асуудал эрхэлсэн газрыг оруулаагүй байна. Тиймээс сайдаа харьяа байгууллагаа нэгийг нь илүү үздэг, нөгөөг нь дорд үздэг байдлаа хуулийг хэлэлцэх явцад засч, залруулсан нь дээр байх. Намайг Гадаадын иргэн харьятын асуудал эрхэлсэн газрын даргаар ажиллаж байхад 400 гаруй шижигнэсэн, хил хамгаалах эрхэм үүргээ хамгийн дээдэд тавьсан залуус ирж байсан. Өөрөөр хэлбэл, тухай хилээс ирсэн газарт нь даргаар тавид харьятын байгууллагын хүмүүсийг орлогчоор нь тавьж байлаа. Тэдгээр залуусыг хамгийн сайн мэргэшсэн хүмүүс гэж онцолж үзсэн учир тэр ажлыг хийсэн. Харин одоо тэдгээр 400 залуу буцаад явах байх. Учир нь та бүхэн олонхи учир энэ хуулийг шийдээд явчих байх. Гэхдээ хил хамгаалахаар мэргэшсэн сайхан залуусыг тогтвортой ажиллуулах талаар баталгаа өгч байгаа шүү гэдээ дахин отлох хэрэгтэй.



**УИХ-ын гишүүн С.Чинзориг:** Ямар үндэслэлээр хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хилийн цэрэг хариуцах ёстой гэж үзсэж байгаа вэ. Ер нь төрийн байгууллагуудын бүтэц тогтвортой байвал үйл ажиллагаа хэвийн явуулах том давуу тал болдог. Ингээд чиг үүргийг нь өөрчлөгдсөнөөр гадаадын иргэдэд тавих хяналтад сөргөөр нөлөөлөх үү. Хилийн зурвасыг 15 км илүүгүйгээр гээд хуулийн төсөлд орж ирсэн байна. Тэгэхээр илүүгүй гэхээр зарим газарт нэг км байж болно гэсэн үү. Хидийн зурваст аж ахуйн чиглэллийн үйл ажиллагаа явуулах буюу ялангуяа ашшигт малтмалын хайгуул, олборлолт хийхийг хуулиараа хориглоод өгчих боломж байна уу. Хилийн зурвас доторх хэмжээг улам багасах тусам хилийн зөрчил, хууль бус үйл ажиллагаа нэмэгдэх хандлага ажиглагдах байх. Хилийн бүс гэсэн ойлголтыг байсныг үндсэндээ одоо байхгүй болгож байгаа юм байна. Өмнө нь 30 км байсныг байхгүй болгоод хилийн зурвас гэсэн ойлголт үлдэж байгаа юм байна. Тэгэхээр хилийн бүс 100 км байж байгаад 30 км болоход нийт газар нутгийн хэчнээнийг иргэд бэлчээрээр ашигладаг болсон юм бэ гэдэг статистик тоо баримт хэлэх болож байна уу.

**Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн:** Хилийн шалган нэвтрүүлэх албыг хилийн цэрэгт байлгах үндэслэл нь Монгол Улс хоёр

УЛС ТӨР

# УЧИР ГИШҮҮДИЙГ ТАЛЦУУЛАВ



газар ашиглуулана гэв–

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



хөрштэйгөө хуурай газраар хиллэдэг. Хуурай газраар хиллэж байгаа энэ хилийн хэсэг, боомт газар ч улсын хил. Тэгэхээр улсын хилийн хамгаалалтын нэгдмэл тогтолцоонд энэ шалган нэвтрүүлэх алба багтаж ордог. Шалган нэвтрүүлэх албыг гүйцэтгэх хилийн цэргийн бие бүрэлдэхүүн Монгол Улсын хил хамгаалах тушаал авсан хилийн манаа байдаг. Энэ утгаараа шалган нэвтрүүлэх алба хилийн цэрэгт ирснээрээ улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоо бүрдэж, улсын хил үндсэндээ онгорхой, цоорхойгүй болж байгаа юм. Хилийн зурвасын хэмжээний тухайд гэвэл багасаагүй. 1993 онд батлагдаж байсан хууль дээрээ энэ үг, өгүүлбэрээр явж байсан. Өөрөөр хэлбэл, 15 км-ээс илүүгүй гэж байсан шиг ээ л байгаа. Монгол Улсын хил дээр байгаа төв суурин газрууд харилцан адилгүй улсын хил дээр байрлаж байдаг. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум улсын хилийн шугамаас  500 мерт байрладаг. Дорнод аймгийн Чулуун хороот сум 1.6 км гэх мэтээр байрлаж байдаг. Тиймээс сумдыг хилийн зурваст оруулахгүй байх гэсэн зохицуулалт яваад байгаа юм. Түүнчлэн хилийн зурваст ашигт малтмалыг ашиглах, хайх асуудлыг тухайд Ашигт малтмалын хууль дээрээ үүнийг Засгийн газрын бүрэн эрхийн асуудал гээд заачихсан байдаг. Тиймээс энэ асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулах боломжтой гэж бид үзэж байгаа. Хэрвээ энэ хуулиар хориглочихвол хоёр хууль зөрчилдөх юм билээ. Тиймээс бид үүнийг өнөөдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуультай зохицуулсан асуудал юм.



**УИХ-ын гишүүн Н.Оюундарь:** Хилийн цэргийн тухай хуулийн найруулгын төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Хэлэлцүүлгийн явцад засч, залруулах шаардлагатай олон заалт байгааг анхаарах хэрэгтэй. Өмнөх парламентаар Хилийн боомтын тухай хуулийг баталж, мөрдүүлсэн боловч тодорхой үр дүн хараахан гараагүй. Одоогийн хилийн цэргийн тухай асуудлыг цогцоор нь шийдвэрлэж байгаа нь илүү үр дүнтэй. Тиймээс Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын 1.1.2 дугаар зүйлд, Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал багтана гэж заасан байдаг. Монгол Улсын язгуур эрх ашгийг хилийн аюулгүй байдлын чиглэлээр учирч болзошгүй аюул, эрсдэлтэй байдаг. Гэтэл энэ эрсдэлтэй тэмцэх бүтэц, арга барил, техник технологи, боловсон хүчин маань манайд төдийлөн хангалттай биш гэж ойлгож байгаа. Одоогийн байдлаар бид зөвхөн ил зөрчсөн этгээдүүдтэй л тэмцээд байж байна. Харин бид эсрэгээрээ энэ хуулиараа дамжуулан боловсон хүчнийхээ бүтцийг боловсронгуй болгох, арга барил, техник технологио шинэчлэх асуудал дээр онцгой анхаарах ёстой. Тэгэхээр үүнд санхүү, мөнгөнийнхөө асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа вэ. Боловсон хүчнийхээ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ. Мөн дэлхийн бүх улс оронд хил хамгааллын үндсэн зарчим нь манайхны яриад байгаа бүсчилсэн байдлаар хамгаалдаггүй. Дэлхий дээр ер нь ийм бүсчилсэн байдлаар хил хамгаална гэсэн ойлголт байдаггүй. Харин дэлхий дээр байдаг хамгаалал нь болзошгүй аюул ослоос хамгаална, сэргийлнэ гэсэн байдаг. Одоогийн хуулиар бүсчлэн хамгаалах гээд заасан байгаа. Үүнийг яаж өөрчлөх вэ.



**Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн:** Бид боловсон хүчнээ бололцооныхоо хэрээр бэлтгэж, чадваржуулж яваа. Дотоодын нэлээд хэдэн сургууль, ОХУ болон бусад гадаад улс орнуудад бэлтгэж байгаа. Манай боловсон хүчний чадвар чансаа шаардлагын төвшинд нэлээн дөхнө. Цаашид чадвар чансааг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. Бүсчилсэн хамгаалалтын агуулга нь таны хэлсэнтэй яг нэг. Өөрөөр хэлбэл, би танд нэг тодорхой жишээ хэлье. Манай Увс аймгийн хилийн хэсэгт үүрэг гүйцэтгэж байгаа хил хамгаалах застав, салбарын хилчид өдөр, шөнөгүй ёстой унтах нойргүй тэнд хил зөрчигчидтэй тэмцэж яваа. Хил дамнасан малын хулгайн чиглэлээр. Гэтэл бусад тал хээрийн бүсэд байгаа хилийн отрьяруудад хилийн цагийн байдал нь харьцангуй тайван байдаг. Ялгаа их байна. Зун ямаа ч тогтдоггүй хилийн заставууд байна. Идэх нэг ширхэг ч өвс байхгүй. Бид дандаа борц, консервоор махыг нь орлуулж байна. Гэх мэтчилэн ийм олон ялгааг нь энэ хуулийн заалтдаа оруулъя. Өөрөөр хэрбэл, цас ордог газар нь бид цанаар хангая. Цас ордоггүй газар нь бусад юмаараа хангая гэсэн санаа энэ дотор явж байгаа юм.



**УИХ-ын гишүүн Г.Занданшатар:** Би дэмжихгүй талдаа үг хэлэх гэж байна. Учир нь хуучин хуулиар улсын хилийн бүсийг түүнд мөрдөх журмын тухай 26 дугаар зүйлийг бүгдийг нь хассан мөртлөө улсын хилийн бүсийг хил орчмын нутаг дэвсгэр гэсэн хуучин 29, одоогийн 30 дугаар зүйлтэй зарим хэсгийг нь нийлүүлсэн байгаа юм.  Шинэ хуулийн. Сэргэлэн генералын хэлж байгаагаар оршин суугчдад илүү хөнгөлөлттэй болсон юм шиг хэлж байгаа боловч хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хамруулаад 30.2, 3, 4 дүгээр зүйлүүдээр 100 км дотор биш нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамруулчихаж байгаа болохоор илүү хүндрэлтэй болгож байгаа юм. Нөгөө талдаа зөвшөөрөл олгодогоо бүртгүүлдэг болгож байгаа нь хилийн байгууламжийг, хилийн бүсийн талаархи хуучин ойлгож тогтож ирсэн соёл, дэглэм, зарчимд өөрчлөлт оруулж байна. Үүнийг хуучин хилчид юу гэж үзэж байгаа юм. Улсын хилийн бүс түүнд мөрдөгдөх журмын тухай хуулиар энэ зохицуулалтыг хил хамгаалах байгууллага өөрөө зохицуулах боломж байсан. Учир нь 26.1 дүгээр зүйл дээр “Хилийн бүсийн өргөнийг хил хамгаалах байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс хэтрүүлэхгүйгээр тогтооно” гэж байна. Хэтрүүлэхгүйгээр тогтооно гэж байгаа юм. Энэ дотор бол хангай хээрийн бүсэд зарим газар хэдэн км байдаг юм. Илүү өргөн тавилаа гэхэд Байтагбогд баруун хил дээр арай урт тавилаа гэхэд зүүн хил дээр халх голын орчмоор хөшөө, дурсгалын зүйлсээ гаргаад ч юм уу хилийн бүсээ тохирох эсэх нь засаг захиргаатайгаа тохиролцоод үнэхээр эдийн засаг, аялал жуулчлал, хадлан тэжээлийн боломж байвал илүүгээр тогтоох эрх нь журмаараа хил хамгаалах байгууллага Засаг даргатай зөвшилцөөд шийдэж болохоор байгаа. Мөн хил орчмын оршин суугч нь улсын зурвас хүртэл чөлөөтэй зорчиж, нутаглаж, ажил үйлдвэрлэл эрхэлж болно. Ажил үйлдвэрлэл  эрхэлж болно гэдэг дотор оршин суугч нь хадлан тэжээлээ бэлтгэх нь нээлттэй байгаа гэж үзэж болно. Гэтэл тэр хөдөөнөөс малчин өвгөн ирээд хадлангаа хадаж болохгүй байна гэдэг асуудал тавигдаж байгаа бол хил хамгаалах байгууллагын л өөрийнхөө журмаараа хүнд сурталгүйгээр зохицуулалттай шийдэж болох асуудлуудыг олон арван жилээр тогтож ирсэн хилийн соёл болоод хил орчмоор амьдардаг малчин хөгшчүүл үндсэндээ хилчин шиг болсон. Дархан хилээ хамгаалдаг хилийн бүсэд амьдардаг хүмүүс сайн дурын хилчин, гэрээт хилчин гээд байгаа чинь тэр хүмүүс болсон юм билээ. Гэтэл гэрээт хилчин гэдэг нэр томъёо орж ирж байгаа юм. Улсын хилийг гэрээгээр хамгаалдаггүй л байхгүй юу. Улсын хилийг тангараг өргөж л хамгаалдаг юм. Гэрээт хилчин гэдэг шинэ нэр томъёо орж ирсэн. Гэтэл тэнд тангараг өргөсөнтэй ялгаагүй хилийн бүсэд амьдардаг, орж гарч буй хүмүүсийг ажигладаг соёл, дэглэм тогтож ирсэн. Хариуцлагаараа ч гэсэн хилийн бүсийг давсан л бол хил зөрчсөн гэж үздэг. Ийм л соёл, уламжлал явж ирсэн. Энэ бол зөвхөн хилийн аюулгүй байдал, хилийн бүсчилсэн хамгаалалт гэсэн дэвшилттэй заалтууд орж ирсэн боловч хилийн бүсийнхээ үндсэн зарчмыг алдагдуулчихсан. Нөгөө талдаа улсын хилийн зурваст иргэн байгууллага, аж ахуйн нэгжээс явуулж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа юм шиг боловч иргэддээ илүү хүндрэл учруулаад байхаар заалтууд байна. 26 дугаар зүйлийг хассаныг дэмжихгүй байна. Үүнд ахмад хилчид хуучин соёл, уламжлал, хариуцлага гээд олон арван жилийн тогтолцоог алдагдуулж байна гэж шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Тиймээс энэ заалтуудыг дэмжих боломжгүй байна.



**УИХ-ын гишүүн Ц.Нямдорж:** Хилийн цэрэг тайван цагт зэвсэгт хүчний бүрэлдэхүүн байх эсэх том маргаан явагдсан. Тайван цагт Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн багтахгүй гэдэг шийдвэр гаргаж байсан. Үүнээс бол Ж.Энхбаяр гишүүний аав бид хоёр ордны нэгдүгээр давхарт миний өрөөнд орж, янз бүрийн яриа болж байж ойлголцож байсан түүх бий. Үүнээс хойш 23 жилийн хугацаанд үүнийг гүйцэлдүүлэх далд сонирхол олон жилийн хугацаанд тээж явж байгаа. Ц.Нямдорж хилийн цэргийг хилийн цагдаа болгох гэж байна гэх яриа бүтэн 14 хоногийн хугацаанд явуулчихлаа. Ийм муу яриа яваад байгаад би харамсаж байна. Ер нь хил хамгаалах байгууллага бие дааж үйл ажиллагаа явуулах учиртай. Дотоодын аюулгүй байдлыг хангадаг гол хүчний байгууллагын нэг. Тиймээс олон жил сунжирсан маргаанд цэг тавих шаардлага байгаа. Ц.Нямдорж гэдэг хүн удирдаж байсан салбараа татан буулгах санал гаргана гэж яаж тарааж чадав аа. Зарим гишүүд ээ. Би удирдаж байсан байгууллага сайжруулах гэж л явсан болохоос татан буулгах буюу муутгах ажил хэзээ ч хийж байгаагүй. Цаашдаа ч хийхгүй. Би эндээс холдсон ч бараг өдөр болгон холбогдох хүмүүс рүү утас цохиж, тэр анги чинь юу болж байна энэ асуудлыг яах гэж байна гэж асууж явдаг. Энэ асуудлаар далимдуулаад цагдаа хил хамгаалж чадахгүй гээд цагдааг муулаад авч байна. Хилийн цагдаатай газар байдаг. Эрхэм гишүүд минь энэ хуулийг дэмжээд өгөөч гэж хүсмээр байна. Хэлэлцүүлгийн явцад гишүүдийн анхаарлыг татаад байгаа зарим асуудал дээр ярилцаж болох байх. Ямар ч тохиолдолд тайван цагт хил хамгаалах байгууллагыг зэвсэгт хүчний удирдлага оруулж огт болохгүй. Онолын болоод үйл ажиллагааны хувьд ч болдоггүй, таардаггүй юм.



**УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн:** Хилийн бүсийн асуудлыг байхгүй болгож байгааг дэмжихгүй байгаа юм. Тийм учраас энэ асуудлыг бид нэлээд нухацтай ярьж шийдэхгүй бол болохгүй гэдэг байр сууринаас хандаж байгаа юм. Тэнд хилийн дэглэм  сахиулах үйл ажиллагаа явагдах бололцоо заавал тодорхой зурвас байж хийгдэнэ. Ялангуяа манайх шиг бартаатай газар нутаг дээр бол нэлээн гүн байдаг. Гэтэл одоо хилийн зурвасын үйл ажиллагаа хэрвээ байхгүй болоод эхлэх юм бол ялангуяа манай улсын хойт талын бүсээр алтны олборлолт, нинжа нарын явуулсан үйл ажиллагаа хилтэй их ойролцоо. Тэр рүү ашигт малтмалын олборлолт хийж эхэлнэ. Эмх замбараагүй байдал үүснэ. Хилийн зөрчил гарна. Ингээд хилийн дэглэм сахиулахад тодорхой хүндрэлүүд учирна гэдгийг нэгдүгээрт хэлье гэж бодсон юм. Хоёрдугаарт, Хилийн цэргийн тухай хуульд өөрчлөлт орж байгаатай холбогдуулаад зарим нэг зүйлийг хэлье гэж бодож байна. Ер нь эх орноо хамгаалж яваад эндэж байгаа, хил дээр байж байгаад идэр залуу насандаа амь үрэгдэж буй энэ хүүхдүүдийг өмнө нь суурь өвчтэй байсан гээд хаядаг байсан. Их муухай зан гаргасан. Би одоогийн шинэ удирдлагыг арай тэгэхгүй байх гэж бодож байна. Энэ зун дахиад хүн эндсэн. Би энэ дээр дуугүй өнгөрсөн. Цаашид хил дээр нэг цэгт хүн эндээд байвал энэ асуудлыг яах юм бэ гэдгийг бодох хэрэгтэй. Энэ зун дахиад эндсэн. Тэгсэн мөртлөө эд залуу насны хүүхдүүдийг хоёр, гуравхан жилийн дотор долоо, наймаар нь үхүүлчихээд суурь өвчтэй байсан гээд өөрсдийгөө өмөөрөөд, хамгаалаад суугаад байдаг. Үүнийг анхаарах хэрэгтэй. Хэрвээ хил хамгаалах явцад залуусын амь нас, эрүүл мэндийг яах юм. Тусгай хэрэглэл хувцас байдаг юм уу, үгүй юу. Устай газар яах юм гэх мэтчилэн хангамжийн асуудлуудыг энэ хуульд ярья гэж байгаа нь зөв. Тэгж тус тусад нь авч үзэх ёстой. Харин хил хамгаалах явцад амь эрсдэх тохиолдол гарах юм бол ар гэрийн хангамж, нийгмийн асуудлыг хуульд оруулж өгөх хэрэгтэй. Үлдэж байгаа хүүхдүүдийг нь яах ёстой юм. Тэтгэмж хэр хугацаагаар өгөх ёстой юм гэх мэтчилэн зүйлийг бид анхаарах ёстой. Хилийн цэргийн хуулийг бид хэлэлцэхдээ хэд хэдэн асуудлыг нухацтай давхар шийдэхгүй бол болохгүй зүйлүүд байгааг хэлэх ёстой. Ер нь манай батлан хамгаалах үзэл баримтлал манай хилийн цэргийн хамгаалалтан дээр чиглэсэн рүүгээ илүү хөгжих нь зүйтэй байх л даа. Бид дэлхийн хамгийн том хүчирхэг хоёр армын өмнө батлан хамгаалахын талаар ярих нь инээдтэй зүйл. Гэхдээ хил хамгааллын асуудал хамгийн чухал. Тийм учраас хэлэлцэх дээрээ хүрвэл энэ асуудлуудыг нэлээд нухацтай ярихгүй бол болохгүй нь. Бид сүүлийн үеийн хуулиуд дээр анхаарахгүй бол болохгүй. Өчигдөр бид хууль зөрчсөн олон улсын гэрээг УИХ хүчингүй болгодог байсан заалтаа бид аваад хаячихаж байгаа шүү дээ. Одоо ямар гэрээнүүд орж ирэх гээд байгаа юм бүү мэд. Хууль зөрчсөн гэрээг УИХ хүчингүй болгоно гэсэн Үндсэн хуулийн эрхээ эдлэх 23 дугаар заалтыг олон улсын гэрээнээс авч хаясан. Энэ мэтчилэн бид анхааралтай хандахгүй болбол хил хамгаалах асуудал үндэсний аюулгүй байдалтай холбоотой зүйлүүд. Тиймээс энэ хуулиудыг хэлэлцэх юм бол маш нухацтай ажлын хэсэг гаргаж хэлэлцье. Шуурхайгаар шийдэж болохгүй. Алт олборлохын төлөө хилийнхээ зурвасыг байхгүй болгож болохгүй. Би ажлын хэсэг гаргаж, нэлээд нухацтай хандах шийдвэрлэх ёстой хууль гэж л бодож байна.



**УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр:** Өнгөрсөн параламент буюу монголын улс төрийн хамгийн олон намын төлөөлөлтэй параламентаар Ц.Нямдорж гишүүний яриад байгаа 20 гаруй жил үргэлжилсэн улс төрийн өөр, өөр байр суурийг нэгтгэж, Монгол төрийн бодлого гарч чадсан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлагдсан. Үүнтэй холбоотойгоор гадаад бодлогын болоод батлан хамгаалахын бологын үзэл баримтлал батлагдсан юм. Батлан хамгаалах бодлогын үзэл баримтлал дотор Төрийн цэргийн байгуулалт гэдэг эрх зүйн шинэ нэр томъёо орж ирсэн. Үүн дотор зэвсэгт хүчин хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага нь төрийн цэргийн байгуулалтын бүрэлдэхүүн байна гэж заасан. Салбар хооронд ойлгомжгүй явж байсан хлийн цэргийн зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд оруулах асуудал нэг мөр шийдвэрлэгдсэн. Тиймээс хилийн зэрэг зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд орно гэдэг тийм зүйл байхгүй гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна. Миний хэлж байсан зүйлүүд Монгол Улсын хил халдашгүй байх тухай Үндсэн хуульд тусгагдсан үзэл санааг илэрхийлж байгаа. Аливаа төрийн бодлого нь өөрөө түүнийг дагаж гарах ёстой салбарын хуулиуд хоёрдмол утгаггүй бодоготойгоо нийцэж гарах ёстой. Гэтэл батлан хамгаалах бологыг дагаж гарах ёстой хилийн хууль  маань хуулийнхаа үндэслэлд батлан хамгаалах бодлого ч тусгалгүй бодлогод тусгагдсан нэр томъёог ч хэрэглэхгүйгээр хоёрдмол утга санаа оруулсан зүйл гарсан. Тухайлбал, газар, усан дээрх улсын хилийг хил хамгаалах байгууллага, агаарын хилийг агаарын цэрэг хагаална гээд хоёр салаа утга ойлгогдохоор томъёолж байна. Энэ мэт зүйл олон байна. Тэгэхээр улсын хил хамгаалах үндсэн хүч хэрэгсэл бол хилийн цэрэг байх ёстой. Хилийн цэрэг гэж байж гэмээнэ цаана нь олон бодлогын асуудал шийдэгдэх юм. Хилийн цэрэг дотроо дотоодын цэргийг яаралтай байгуулах ёстой. Гэтэл өнөөдөр цагдаагийн бүрэлдэхүүн дотоодын цэргийг байгуулах асуудал хууль зүйн яам дээр явж байгаа. Энэ мэт бодлогоос зөрсөн зөрсөн асуудлуудыг хийж болохгүй. Хууль зүйн сайд  С.Бямбацогт, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэнтэй уулзсан. Улмаар хоёр зүйл дээр ойлголцсон. Тодруулбал, улсын хил хамгаалах хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байна гэсэн томъёоллыг энд оруулж өгнө. Хоёрдугаарт, хилийн цэргийн алба хаагчдыг алба хаах журам, эрх зүйн байдлыг Цэргийн албаны тухай хууль болон Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулиар нэгтгэн зохицуулна гэсэн хоёр зүйл дээр бид ойлголцсон гэж бодож байгаа. Батлан хамгаалах бодлогын хүрээнд хил хамгаалах асуудал байгаа. Тиймээс УИХ-ын даргаас хүсэхэд, хууль зүйн байгын хороо болон аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо эрхлэх ажлын хүрээндээ энэ асуудлыг хамтран хэлэлцэж, ажлын хэсэг гаргаж, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн саналыг гаргаж байна. Улсын хил хамгаалах хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байна гэдэг улс төрийн шийдэл дээр дэмжиж байгаа тохиолдолд энэ хуулийг бид хэлэлцээд, батлах ёстой.

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

# З.БАТЗОРИГ: ХҮНИЙ Т
# ХӨГЖЛИЙН ТӨЛ



Э.ТУУЛ

*Булган аймгийн Засаг дарга З.Батзоригийг энэ удаагийн дугаартаа урьж, ярилцсанаа уншигч түмэндээ хүргэж байна.*

**-Энэ зун сонгуулиар илт давуу ялалт байгуулж, аймгийн Засаг даргаар сонгогдсон. Ажлаа аваад багагүй хугацаа өнгөрлөө. Цаг агаарын байдал ч нэлээд хүндэрчихлээ. Булган аймагт өвөлжилт нэлээд хүндэрч байгаа талаар салбар яамнаас мэдээлэл өгч байна. Тэгэхээр өвөлжилт хэр байгаагаас ярилцлагаа эхлэх үү?**

-Юуны өмнө танай сониноор уламжлан нийт булганчууддаа өнгөрсөн УИХ болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд Монгол Ардын Намд итгэл хүлээлгэн бид бүхнийг багаар нь сонгосонд талархаж байгаагаа илэрхийлье.

Манай аймгийн хувьд өвөлжилтийн бэлтгэлээ сайн базаасан. Аймгийн Засаг даргын захирамжаар мал аж ахуйн болон төв суурин газрын өвөлжилтөд бэлтгэх комисыг томилж ажиллуулсан. Нөгөө талаар өнгөрсөн аравдугаар сарын 19-нд болсон орон нутгийн сонгуультай холбоотойгоор орон нутгаас шалтгаалах өвөлжилтийн бэлтгэл хангах ажил нэлээд удаашралтай явагдсан. Ерөнхийдөө улсаас тогтоосон статистик үзүүлэлтээр 86 хувьтай бэлтгэлээ хангасан. 85 хувиас дээш хангах юм бол улсын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангагдсан гэж үздэг учраас энэ үзүүлэлтээр аваад үзэх юм бол манай аймгийг бэлтгэл сайн хангасан гэж үзэж болно.

**-Хадлан, тэжээлийн нөөц хэр байгаа вэ. Ер нь Булган аймагт хэчнээн толгой мал өвөлжихөөр байна?**

-Засгийн газрын 2016 оны 322 дугаар тогтоолоор аймаг, сумын аюулгүйн нөөцөд байх ёстой өвс, тэжээлийн нөөцийг аймгийнхаа нэгдсэн дүнгээр сайн хангасан. 2-3 суманд хангалтгүй байгаа. Тэдгээр сумдын удирдлагуудад үүрэг өгч, тодорхой шаардлагуудыг тавиад ажиллаж байна. Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур сумдад зундаа гандуу, өвс ногооны гарц тааруухан байсан. Аймгийн хэмжээнд 3.5 сая толгой мал өвөлжих төлөвтэй байна. Дашинчилэн сумын нутаг, аймаг, отрын бүсийн нутаг дээр бидний тооцоогоор 30-60 орчим мянган мал отроор нүүдэллэх боломцоотой гэж харж байгаа. Гэвч өнөөдрийн байдлаар Төв, Дундговь зэрэг гурван аймгийн 300 мянга гаруй мал оторлуулах хүсэлт ирээд байна. Энэхүү хүсэлтийг ХХААХҮЯ-нд уламжилсан.

**-Энэ жилийн хувьд нэлээд хүйтэн өвөл болно гээд байгаа шүү дээ?**

-Цаг уурын мэдээгээр Булган аймагт олон жилийн дунджаас хамгийн хүйтэн өвөл энэ жил тохиох төлөв гарсан байна. 2017 оны нэг, хоёрдугаар сард нэлээд хүйтэн өвөл болох, урьд урьдын жилүүдээс хүйтэн өвөл болох төлөвтэй байна. Тэгэхдээ бид цаг агаараас шалтгаалаад, алмайрч суулгүй боломжоороо бэлтгэлээ хангаж, энэ өвлийг өнтэй давах талаар онцгой анхааран ажиллаж байна.

**-Малын гоц халдварт өвчин гарсан талаар мэдээлэл гарч буй. Одоогийн байдлаар нөхцөл байдал ямар байна. Хэдэн суманд, хэчнээн тоо толгой мал өвчлөөд байна вэ?**

-Өнөөдрийн байдлаар манай аймгийн Могод, Гурванбулаг сумдад хонины гоц халдварт цэцэг өвчин гараад байгаа. Могод суманд бол цэцэг өвчний голомтод долоон айлын 7600 гаруй мал байгаагаас 4500 нь хонь. Энд найман пост гаргаад, нийт 71 хүн, 20 гаруй техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байна. Ерөнхийдөө Могод суманд голомтыг нэлээд сайн хумьж чадлаа. Мөн Гурванбулаг суманд гурван газар цэцэг өвчний голомт илрээд хорио цээрийн дэглэм тогтоогоод ажиллаж байна. Урьдчилсан байдлаар 20 гаруй айлын 20 мянга орчим хонийг хорио цээрийн бүсэд оруулсан. Нөхцөл байдал Гурванбулаг суманд хүндрэх төлөвтэй байна. Гэхдээ бид аймаг орон нутгаас шалтгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Сум бүрэн боломжоороо ажиллаж байгаа. Аймгийн онцгой комисс голомтын бүс болгон дээр пост ажиллуулж эхэлсэн. Мөн устгалын болон үнэлгээний комисс байгуулж, устгалд оруулж буй малыг маш гүнзгий нүхэнд булж байна. Энэ ажилд хэрэглэгдэх техник хэрэгслийг боломжоороо зохицуулаад, хүн хүчээ хуваарилаад шуурхай ажиллаж байна. Түүнээс гадна малын халдварт өвчинтэй холбоотойгоор вакцин нэлээд яаралтай шаардлагатай байгаа боловч улсын хэмжээнд вакцины нөөц их тааруу байдаг юм байна. Манай холбогдох мэргэжилтнүүд ХХААХҮЯ-тай байнга холбогдож байгаа. ОХУ-аас вакцин оруулж ирэх сурагтай байна. Вакцин 7-14 хоногийн хугацаанд орж ирнэ гэсэн мэдээтэй байна.

**-Ер нь ямар төсөвтэй, ямар чадавхитай аймаг хүлээж авав. Ажлаа хүлээж авснаасаа хойш ямар ажлуудыг хийж, амжуулав?**

-Манай аймгийн хувьд Сэлэнгэ мөрний усыг “Эрдэнэт үйлдвэр”-т ашиглуулдаг, улсаас татаас авдаггүй цөөхөн аймгуудын нэг. Үүгээрээ санхүүжээд гол ажлаа хийгээд явдаг. Ерөнхийдөө нэгдсэн дүнгээрээ нэг тэрбум орчим төгрөгийн төсөвтэй аймаг хүлээж авсан. Мөнгөн дүн нь том боловч энэ мөнгийг бид юунд ч зарцуулж чадахгүй байгаа. Учир нь оны эцэс болчихсон, бүх төрийн болон төсвийн байгууллагын ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхөд энэ мөнгө хүрэлцэхгүй болчихож байгаа юм. Тэгэхээр нөгөө талаас нь тайлбарлахад аймаг маань хэцүүхэн санхүүтэй байгаа гэж хэлж болно. Ер нь ганц манайх ч гэлтгүй нэлээд олон аймаг ийм байдалтай байна. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд бидний хийсэн хамгийн том ажил бол 2016-2020 онд хэрэгжүүлж ажиллах аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг боловсруулж, батлуулсан явдал. Бусад аймгуудтай харьцуулахад, бараг эхний нэг, хоёрт шахам мөрийнхөө хөтөлбөрийг боловсруулж, батлуулаад хэрэгжүүлээд эхэлчихсэн. Эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор 2016, 2017, 2018 онуудад төвлөрсөн хөрөнгө оруулалт улсын хэмжээнд бага ирэх юм билээ. Тиймээс бид гадаад харилцаагаа нэлээд сайн өргөжүүлье, эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг бий болгоё, гадна, дотны хандивлагч байгууллагууд, томоохон бизнесүүдтэй холбогдъё, тэдний эдийн засгийн сонирхлыг Булган аймагт бий болгоё гээд, нэлээд ажил зохион байгуулсан нь түрүүчээсээ үр дүнгээ өгч эхэлж байна.

**-Аймгийн Засаг даргын зөвлөл шуурхай хуралдаж байсан. Ерөнхийдөө ямар асуудлыг голлож ярилцав. Ямар шийдэлд хүрэв?**

-Бид Засаг даргын зөвлөлийн хурлаар есөн асуудлыг хэлэлцлээ. Тухайлбал, 2016 оны ургац хураалтын дүнг сонслоо. Манай аймаг энэ жил өмнөхөөсөө харьцангуй их ургац хураалаа. Аймгийнхаа хэмжээнд 53 800 гаруй тонн ургац хурааж авсан байна. Энэ нь 1993 оноос хойш авсан хамгийн их ургац гэсэн сайхан мэдээтэй байна. Мөн оны эцэс болж байгаа тул аймгийн сайн малчин, сайн тариаланч, тэргүүний тариаланч хамт олон шалгаруулах болзолт журмуудаа шинэчилж баталлаа. Энэ бол орон даяар хийгддэг ажил. Булган аймагт маань мал аж ахуйн гол хоёр брэнд байдаг. Нэг нь Хангайн бүсийн нарийн ноостой хонь. Нөгөөх нь Сэлэнгэ аймагт байдаг Сэлэнгэ үүлдрийн үхэр. Сэлэнгэ үүлдрийн үхэрт ангилалт явуулсан мэдээгээ сонслоо. Энэ үүлдрийг гаргаж ирснээрээ Булган аймгийн нэлээд хүн Төрийн соёрхолт хүртсэн байдаг юм. Өнөөдөр энэ үүлдрийн маань үхрийн нөхцөл байдал ямархуу байна, цаашид бид яах ёстой юм гэдэг дээр мэдээлэл сонсч, шийдвэрүүдээ гаргалаа. Мөн мал тооллогын асуудал мэдээж орон даяар чухалд тооцогдоно. Тэгэхээр мал тооллогыг яаж зохион байгуулах юм. Ялангуяа малын гоц халдварт өвчин гарсан Могод, Гурванбулаг суманд мал тооллогыг яаж зохион байгуулах вэ гэдэгт нэлээд анхаарч ярилцлаа. Үүнээс гадна арванхоёрдугаар сарын 5-нд аймгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн ээлжит III хуралдаан болно. Энэ хурал дээр тавих аймгийн нийгэм, эдийн засгийн 2016 онд хөгжүүлсэн зорилтын хэрэгжилт, 2017 оны зорилтын хэрэгжилтийг сонслоо.

Өнгөрсөн хугацаанд хийгдсэн багагүй ажлуудыг сонссон. Анхаарах зүйлүүд байна. Мөн бид бүхэн Засгийн эрх аваад аймаг орон нутагтаа төрийн байгууллагын үйлчилгээний шуурхай байдлыг хангая, хүнд суртлыг арилгая гэдэг үүднээс “Инээмсэглэн угтаж, баярлуулан үдье” гэдэг аян зарласан. Учир нь өнгөрсөн хугацаанд манай төрийн албаны чадавхи доройтсон байна, хурд нь саарсан байна. Ард иргэдээ хүндлэхээ больсон байна. Тийм учраас бид төрийн байгууллага болгон стандарт тогтоо гэж байгаа юм. Нэг иргэн ороод ирэхээр мэдэхгүй, чадахгүй гээд явуулчихдаг. Баян цатгалан хүн ороод ирэхээр ажлыг нь таван минутад бүтээгээд явуулдаг. Ийм зүйл байж болохгүй. Ямар ч иргэн орж ирсэн 15-20 минутын дотор үйлчилгээ үзүүлээд, инээгээд гаргадаг стандартыг тогтооё, цуг сууж байгаа хүнийхээ юу хийж чаддагийг нь мэдье. Адаглаад хүнтэй сайхан харьцдаг байя. Өглөө гэртээ ямар ч асуудалтай ажил дээрээ ирсэн тухайн өдөр тэр хүн ажлаа л хийх ёстой гэсэн иймэрхүү наад захын асуудлуудыг ярилцаад, энэ аяныг зохион байгуулахаар болсон. Аяныхаа үр дүнг үзэж байж дараагийн аянаа зохионо. Ерөнхийдөө хурлаар тодорхой чиглэлүүд гарсан байгаа.

**-Таны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт яг ямар асуудлууд нэлээд гүнзгий орсон бэ. Ер нь юуг хамгийн түрүүнд хөгжүүлчихвэл, хийчихвэл энэ аймаг хөгжинө гэж та харж байна вэ?**

-Аймгийн Засаг даргын хөтөлбөр нь дунд хугацаанд Булган аймгийг хөгжүүлэх гол хөтөлбөр учраас бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын санал бодлыг сонсож, боловсруулалт хийж тусгалаа.

Тийм учраас аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт ард иргэдээ нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, зөв засаглал, хууль, эрх зүй, аюулгүй байдал зэрэг таван үндсэн чиглэлээр хөгжүүлэхэд анхаарч, тэдгээрт 70 зорилт, 383 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. Нөгөөтэйгүүр өнөөдөр иргэдийн амьдрал, орлого, сэтгэл ханамж хэр байгаа билээ, өнгөрсөн хугацаанд гаргасан бодлогын алдаа, оноо юу байв гэдэгт үнэлгээ хийж, дүгнэх нь чухал. Хөтөлбөрийн амин санаа нь хүний төлөө эдийн засгийг цогцлоож, хөгжлийн төлөө зөв бодлого баримтлахад чиглэнэ. Аймаг, орон нутгийн үе үеийн удирдлагуудын хүрсэн ололт амжилтыг бататгаж, алдаа дутагдлыг залруулан, эдийн засгийн хөгжлийн салаа мөчир бүрийг иргэдийнхээ амьдрал, орлогыг дээшлүүлэх, дэмжин тэтгэхэд чиглүүлнэ. Өнөөдөр ард иргэдийн маань дунд ажилгүйдэл маш их байна. Ядуурал их байна. Тийм учраас энэ мөрийн хөтөлбөрийн эцсийн цаад зорилго Булган аймгийн 61 мянган иргэний амьдралыг дээшлүүлэхэд л чиглэж байгаа юм.

> ...Бид бүтээн байгуулалт хийгээд яах юм, өнөөдөр хүн орохгүй байгаа олон барилга байна. Үр дүнгээ өгөхгүй байгаа зүйлүүд ч байна. Бид эцсийн дүндээ ард иргэдийн амьдрал ахуй, халаасан дахь орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн зүйлүүдийг мөрийн хөтөлбөртөө тусгаж, шингээгээд явж байгаа юм. Бид засгийн эрх авснаасаа хойш ахмадууд, залуучууд эмэгтэйчүүдтэйгээ уулзлаа. Бизнес эрхлэгчидтэйгээ уулзлаа...

Бид бүтээн байгуулалт хийгээд яах юм, өнөөдөр хүн орохгүй байгаа олон барилга байна. Үр дүнгээ өгөхгүй байгаа зүйлүүд ч байна. Бид эцсийн дүндээ ард иргэдийн амьдрал ахуй, халаасан дахь орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн зүйлүүдийг мөрийн хөтөлбөртөө тусгаж, шингээгээд явж байгаа юм. Бид засгийн эрх авснаасаа хойш ахмадууд, залуучууд эмэгтэйчүүдтэйгээ уулзлаа. Бизнес эрхлэгчидтэйгээ уулзлаа. Засаг даргын дэргэд эдийн засгийн орон тооны бус зөвлөлийг байгуулсан. Булган аймагт үйл ажиллагаа явуулж байгаа банкны захирлууд, томоохон бизнес эрхлэгчидтэй уулзаж, өнөөдөр бизнес эрхлэхэд Булган аймгийн зүгээс, төр захиргааны байгууллагын зүгээс ямархуу хүнд суртал, алдаа дутагдлууд байна. Үүнийг яаж засч, залруулах вэ гэдэг асуудал дээр тэднийхээ санаа оноог сонсч, тогтож ярьж, чиглэл өгөөд байгаа. Бас нэг зүйлийг өнгөрсөн хугацаанд хийлээ. Тэр юу гэвэл, тендер хуулийн хүрээнд л явагддаг шүү дээ. Гэхдээ бид тендерүүдийг, ямар нэгэн худалдан авалтыг болж өгвөл аймаг, орон нутгаасаа авах, аймаг орон нутгийнхаа бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдээс авах уриалга гаргаад хэрэгжилтэд нь хяналт тавиад явж байна.

**-Орон нутгийн хөгжлийн сан ямар чадавхитай вэ. Иргэд өөрсдийнхөө саналаар энэ сангаас хийгдэх ажлыг тогтоодог болсон. Тэгвэл Булганчууд ямар ажил хийгээсэй гэж хүсч байна. Та их олон хүнтэй уулзсан байна шүү дээ?**

-Ер нь л ажлын байр бий болгох. Эцсийн гол зорилго л тийм байна. Өнөөдөр над дээр ажил хайж орж ирж байгаа маш олон хүн байна. Бүгд л ажил гэж байна. Социализмын үед хүн бүхэн ажилтай байсан. Цалин их, бага нь хамаагүй бүгдээрээ л ажилтай байсан. Өнөөдөр бол үнэхээр ажилтай хүн, ажлын байр гэдэг зүйл хомс болсон юм байна, эдийн засгийн хүндрэлээс шалтгаалаад. Дээр нь хүн бүхэн төрд ажиллахыг хүсдэг болсон байна. Тэгэхээр энэ хандлагыг өөрчлөх ёстой гэсэн бодол өдрөөс өдөрт толгойд бат сууж байна даа.

**-Тэгэхээр аймгийн хэмжээнд ажлын байр нэмэгдүүлэх ямар боломж байна вэ?**

-Манай аймгийн Бүрэгхангай,

ЦАГ ҮЕ

# ӨЛӨӨ ЭДИЙН ЗАСГИЙГ ЦОГЦЛООЖ, ӨӨ ЗӨВ БОДЛОГО БАРИМТАЛНА

Дашинчилэн сумдад алт болон уул уурхайн чиглэлээр хэд хэдэн байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Өмнөх Засаг дарга нар газар шороогоо ухуулах талаар бодлого барьж байгаагүй, би ч гэсэн бас дэмжихгүй гэж боддог юм. Хэрэв уул уурхайгаа ухах болох юм бол дараа дараагийн үе маань л ухна биз. Өнөөдөр манайд байгаа хамгийн давуу тал бол мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал. Үүнийг л бид ашиглая. Энэ давуу тал дээрээ түшиглээд ажлын байраа нэмэгдүүлье гэсэн бодолтой байгаа. Мэдээж би боловсролын салбарт ажиллаж байсан учраас ер нь ямар ч улс орны тэргүүлэх салбар боловсрол байх ёстой гэж боддог.

Манай боловсролын салбарт тулгамдаж байгаа асуудлууд нэлээд байна. Тэгэхдээ манай Булган бол үе үеийн дарга, их хурлын гишүүд, сайд удирдлагуудын ач тусаар боловсролын салбарын орчин нь бусад аймгуудтай харьцуулахад сайхан хөгжчихсөн.

Одоо харин чанарын асуудлыг л бид энэ дөрвөн жилийн хугацаандаа маш сайн хөндөнө гэж бодож байна. Мөн эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн асуудал байна. Ганц Булганд байгаа юм болов уу гэсэн нэлээд олон аймагт байдаг юм байна. Эрүүл мэндийн салбарын шинэчлэл гэхээр нэг зүйл тойроод яриад байж болохгүй юм шиг байна билээ. Олон зүйл байна л даа. Удирдлага менежмент, тогтолцооны асуудал байна. Хүмүүсийн хандлага сэтгэхүйн асуудал байна. Энэ мэтчилэн шийдэх ёстой олон ажил байна. Ер нь олон талаас нь сайн судалж байж шийдлээ гаргаж хийхгүй бол болдоггүй юм байна. У.Хүрэлсүх сайдын хэлсэн шиг судлах гэж дарга болоогүй, шийдэх гэж дарга болдог гэдэг шиг шийдлүүдээ л гаргах гээд явж байна даа.

**-Булган бас ч гэж аялал жуулчлал хөгжих боломжтой газар шүү дээ. Рашаанаа тойруулаад аяллын маршрут гаргасан ч болох юм шиг санагдаж байна?**

-Аялал жуулчлалын тухайд манай аймагт төдийлөн хөгжөөгүй. Урд талын Өвөрхангайн замд байдаг Элсэн тасархайн хэсэгт хамаг гайгүй гэсэн аялал жуулчлалын баазууд байна. Ер нь зуны идэвхтэй хоёр сард бол Хөвсгөлийн чиглэлд хүмүүс их явдаг. Тиймээс тэр зам дээр бид ашиглалтай байрлалаа бий болгох хэрэгтэй байгаа юм. Уг нь бол Хөвсгөлөөс илүүтэйгээр Тэшиг гээд ямар сайхан байгальтай газар нутаг байгаа билээ.

Хутаг-Өндөр гэдэг ямар сайхан байгальтай билээ. Тиймээс бид энэ тал руугаа нэлээд анхаарья гэж бодож байгаа. Босоо тэнхлэгийн зам Рашаант, Гурван булаг, Хишиг-Өндөр, Орхон, Булган тэгээд Хөвсгөл гээд холбогдоод ороод ирэхээр хойд чиглэлийн замын маань ачаалал багасаад урд руугаа ороод ирнэ. Энэ хугацаанд бид зам дагуух сайн байрлалуудыг хөгжүүлэх шаардлагатай болж байгаа юм. Мөн манай аймгийн нэг онцлог нь бараг бүх суманд эмчилгээний чиглэлийн рашаан бий. Энэ давуу тал дээрээ бас тулгуурлана. Өнөөдөрдотоодын аялал жуулчлал, нийгэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор хүмүүсийн амьдралын төвшин, хэвшил ч өөрчлөгдсөн. Үүнийг зөв сурталчлаад, зөв менежмент хийж чадах юм бол бидэнд боломж байгаа юм болов уу гэж бодож байна.

**-Рашааны талаар хүмүүс сайн мэддэггүй юм шиг санагдсан. Ам дамжсан яриагаар л ирэхээс биш яг ирээд үзэхээр рашааны тухай танилцуулга, түүх домог, юунд сайн рашаан бэ гэдэг нь байдаггүй юм байна билээ?**

-Манай аймгийн Ханүйн рашааныг хүмүүс их сайн мэддэг. Хажууханд нь Цагаан голын рашаан бий. Энэ хоёр рашааныг хүмүүс сайн мэддэг болсон. Бас ч гэж бизнес эрхлээд уддаг болсон байна. Хөвсгөлийн замд байгаа Хутаг-Өндөрийн Их булагийн рашаан гээд хүмүүсийн ярьдгаар сахарын рашаан байна. Энэ дээр бас сүүлийн үед маш их амралтын газар баригдаж байна. Гэвч тэр нь эргээд рашааныхаа байгаль экологийн байдалд нөлөөлж байна. Хогноос эхлээд янз бүрийн асуудал үүсч байна. Магадгүй энэ бүхэн 100 жил ашиглах рашааны маань чанарт нөлөөлөөд 5-10 жилийн настай болчихвол яана. Тэгэхээр энэ асуудлыг цэгцлэх шаардлагатай. Тэшиг суманд л гэхэд бүр Орос, Монголын хил дээр шахам ходоодны рашаан байна. Сэлэнгэ суманд Хоодын рашаан гээд ходоодны рашаан байна. Сайхан суманд хүн ордог шавартай сахарын рашаан байна. Могод суманд халуун рашаан гээд байна. Дашинчилэн, Баяннуур сумын заагт дээр бөөрний рашаан бий. Орхон суманд бас хэд хэдэн рашаан бий. Ер нь бүх сум сайн рашаантай. Үүнийг л бид хөгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Хамгийн гол нь байгаль экологийн үнэлгээг нь хийлгээд, үйлчилгээ явуулах үед нь хяналт сайн тавиад, менежментээ хийгээд явбал аялал жуулчлал хөгжих боломжтой. Тэгэхдээ заавал эмчтэй байх ёстой. Мэдээж түүх, домог нь хэрэгтэй. Хүмүүс их бэлгэшээдэг шүү дээ. Ерөнхийдөө домог болоод орчин үеэ зөв хослуулах хэрэгтэй юм болов уу гэж бодож байна.

**-Аймгийн Засаг даргын ажил үнэхээр их юм. Ажил, амьдралаа хэрхэн зохицуулж байна вэ?**

-Миний хувьд өмнө нь төрийн албанд 10 гаруй жил ажилласан. Аймгийн Монгол Ардын Намын хорооны дэд даргаар ажиллаж байгаад, аймгийн ИТХ-ын сонгуульд төрж өссөн Шинэ хороо буюу 1-р багтаа нэр дэвшиж сонгогдсон. Ингээд аймгийн ИТХ-ын анхдугаар хуралдаанаас аймгийн Засаг даргад нэр дэвшин олонхийн дэмжлэгийг авч, 2016 оны долдугаар сарын 25-ны өдрөөс албан ёсоор үүрэгт ажлаа хүлээн авсан. Хүний хамгийн үнэ цэнэтэй зүйл бол гэр бүл байдаг. Өнгөрсөн зургадугаар сард манайх шинэ хүнтэй болсон, ар гэрийн бүх ажлыг эхнэр маань зохицуулж байна. Тэр бүр гэртээ, хүүхдүүддээ цаг, зав гаргаж чадахгүй л байна. Хоёр талын аав, ээж, ах дүүс тусалж дэмжээд явж байгаа болохоор ар талдаа санаа зовох зүйлгүй, олон түмнийхээ итгэл, хүндлэл, бас хүлээлтэд хүрч ажиллах юмсан гэж ажилдаа л гол анхаарлаа хандуулж байна даа.

**-Таныг боловсролын болон соёл урлагийн салбарынхан андахгүй мэдэх байх. Ер нь З.Батзориг гэдэг хүн хэн болохоо товчхон танилцуулахгүй юу?**

-Минийаав, ээжтөрийналбанд ажиллаж байсан эгэл жирийн хүмүүс. Одоо хоёулаа өндөр насны тэтгэвэртээ суусан. Аав минь Сайхан сумын гаралтай, ээж маань Орхон сумын хүн. Харин би өөрөө аймгийн төвд төрсөн, Шинэ хорооны хүү дээ. Бага насаа Булган хотын дөрөвдүгээр цэцэрлэгт өнгөрүүлж, Улсын тэргүүний нэгдүгээр бага сургуульд элсэн орж, П.Е.Щетинкиний нэрэмжит нэгдүгээр 10 жилийн сургуулийг төгссөн. Арван жилийн сургуулиа төгсөөд МУИС-д элсэн орж суралцсан. Мөн Удирдлагын академийг дүүргэсэн. Япон, АНУ-д мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.



Гурван дүүтэй айлын ууган хүү, мөн 17 ач, зээтэй гэр бүлийн ууган ач. Овог ураг, гэр бүлдээ хариуцлага үүрч ирсэн бол одоо аймгийнхаа нийт иргэдийн өмнө хариуцлага хүлээж, эрх ашгийг хамгаалах эрхэм албыг хашиж байна. Дан ганц боловсролын салбар биш, соёлын салбарт ч бас ажилласан. Тэгэхээр боловсрол, соёлын салбарынхан аль аль нь андахгүй. Анх Боловсрол, соёлын газрын соёлын мэргэжилтнээр ажиллаж эхэлсэн, дараахан нь боловсрол, соёл хариуцсан мэргэжилтний ажлыг давхар эрхэлсэн. Боловсрол, соёлын салбарт өмнө ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа олон сайхан хүмүүстэй хамт ажиллаж, тэр хүндтэй хүмүүсээс их зүйлийг сурч авсандаа баярлаж явдаг. Үүнээс өмнө аймгийн ЗДТГ-т аймгийнЗасаг даргын туслах, төрийн албан хэрэг хөтлөгчөөр гурван жил ажилласан. Ямар хүн хамгийн их мэдээлэлтэй байдаг вэ гэхээр Засаг даргын туслах, банкны зээлийн эдийн засагч хоёр л хамгийн их мэдээлэлтэй байдаг гэсэн наргиа үг бий. Дээр нь аймгийнхаа хамгийн том салбарын хүний нөөцийг барьж байсан хүний хувьд төв, хөдөөд маш олон хүнийг сайн мэднэ.

**-Улсын хэмжээнд болон аймгийнхаа түүхэнд та хамгийн залуу Засаг дарга юм. Булганчууд аливаа зүйлд анхдагч гэдгээрээ их бахархдаг улс. Тэгэхээр хамгийн залуу Засаг даргатай болж, бас л нэг анхдагчтай болж дээ?**

-Энэ сайхан нутагт төрж өссөнөөрөө би бахархаж явдаг. Булганчууд бид аливаа зүйлийг шинээр хийх, түүхэн үүрэг хүлээх гээд чухал мөчүүдэд эх орондоо өргөх тийм нэг хүч байдаг нь сайхан. Гэхдээ нас бол тоо гэдэг нэг үг бий. Өнгөрснөөс сургамж авч, ирээдүйгээ харан өнөөдрөөрөө ажиллаж амьдрах нь бидний барих зарчим.

**-Удирдах албан тушаалд таны боловсрол, ур чадвар, туршлага нэг их дутаад байхгүй юм байна. Гэвч гар, сэтгэл нийлж ажиллахад баг их чухал. Багаа яаж бүрдүүлэх вэ?**

-Миний хувьд ирэх дөрвөн жилд хамтдаа ажиллах багаа бүрдүүлсэн гэж ойлгож байгаа. Одоо бидэнд багийн тоглолт, итгэлцэл чухал. Итгэл алдсан, итгэл даагаагүй тохиолдолд тухай бүрт нь хариуцлагыг нь үүрүүлээд явна.

**-Таныг аймаг удирдах хугацаанд Булган аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ой тохиох юм байна. Одоогоор төлөвлөсөн ажил байгаа юу?**

-Өөрт хоногшсон дурсамжаас хуваалцахад аймаг байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээнд цэцэрлэгийн хүүхэд байхдаа гимнастик хийж оролцож байлаа. 60 жилийг арван жилийн сурагч байсан болохоор анзаарахгүй өнгөрөөсөн шиг байгаа юм. Гэхдээ тэр үеэр бараг айл бүрт цаг, тор, төрийн албан хаагчдад үзэг, балны цуглуулга өгч байсныг санаж байна. 70 жилийн ойн нийгэм, соёлын ажлын хэсэгт ажиллаж, нээлт, хаалт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байлаа.

Удахгүй Булган аймгийн маань 80 жилийн ой тохиох гэж байна. Энэ талаар хийж, бүтээхээр төлөвлөсөн олон зүйл бий. Аймгийн 80 жилийн ойг зохион байгуулах комиссыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгууллаа. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар ажлын таван салбар хороог байгуулан, ажилд нь оруулаа.

"Булган-80" гэсэн нүүр хуудсыг олон нийтийн цахим сүлжээн дээр нээлгэж, иргэд, олон нийтийн санаа бодлыг авч байна. Мөн сум, агентлаг, төрийн бус байгууллагуудаас аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн бүтээлч ажлын саналыгавлаа. Ойрынхугацаанд төлөвлөгөөгөө баталж, хэрэгжүүлэх ажилдаа ханцуй шамлан орно. Хугацааны хувьд хоёр жилийн дараа боловч хийж бүтээхийн талаар ганцхан жилийн идэвхтэй хугацаа байна. Тиймээс бид ажлын хуваарийг маш нарийвчлан гаргаж, зохион байгуулалтаа сайн хийж ажиллах ёстой.

Тухайнүедаймгийн50жилийн ойг зохион байгуулахдаа гурван жилийн өмнөөс, М.Оюунбат дарга аймгийн 70 жилийн ойг зохион байгуулахдаа хоёр жилийн өмнөөс бэлдсэн гэдэг. Тэгэхээр бидэнд цаг хугацаа гэдэг тун үнэ цэнэтэй байна. Ой тэмдэглэнэ гэдгийг дан ганц аймгийн ЗДТГ болон тухайн ойг зохион байгуулах комисс, салбар хорооны гишүүдийн хийх ажил гэж ойлгож болохгүй. Булган аймгийн иргэн бүрт хамаарах, хүн бүхний оролцоо, дэмжлэг, санаачилгад тулгуурлаж хамтдаа хийх бүтээн байгуулалт гэж ойлгох хэрэгтэй. Энэ талаас нь бид бүхэн анхаарч, хамгийн гол нь иргэдэд чиглэсэн тодорхой ажлуудыг зохион байгуулах нь чухал юм.

Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймаг дахь нутгийн зөвлөл, бусад аймгуудад амьдран сууж буй нутгийн уугуул, суугуул болоод ажил хэргийн холбоотой иргэдтэй хамтрах нь энэхүү ойн зохион байгуулалтын бас нэг чухал хэсэг. Нийслэлд байгаа Булган сумын нутгийн зөвлөлийн залуучуудтай уулзаж, санал бодлоо солилцсон. Тэд төрөлх аймгийнхаа 80 жилийн ойг зохион байгуулах талаар олон шинэлэг зүйлсийг санал болгосон, цаашид ч тэдгээр саналуудыг улам боловсронгуй болгон хэрэгжүүлж ажиллана. Түүхэн их ойг тэмдэглэнэ гэдгийг бөх барилдах, морь уралдуулах төдийгөөр хязгаарламгүй санагддаг. Мэдээж 80 жилийн ойн түүхэн ном, наадмын нээлт, хаалт, үзвэр үйлчилгээ зэрэг зүйлс хийгддэгээрээ хийгдэнэ.

Хол ойроос зорьж ирсэн зочид гийчид, нутгийнхаа иргэдийг сэтгэл хангалуун, нуруу тэнэгэр үзэж харах, ярих зүйлтэй, төрөлх нутгаараа бахархах сэтгэлийг бадраан омогшуулсан тийм ажлыг зохион байгуулах болно. Нөгөө талаас их ойд чиглүүлэн хийж хэрэгжүүлж, бүтээн байгуулж буй бүх ажлын үр дүн энэ нутгийн иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэх учиртай.

...Удахгүй Булган аймгийн маань 80 жилийн ой тохиох гэж байна. Энэ талаар хийж, бүтээхээр төлөвлөсөн олон зүйл бий. Аймгийн 80 жилийн ойг зохион байгуулах комиссыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгууллаа. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар ажлын таван салбар хороог байгуулан, ажилд нь оруулаа...

# ЭМГЭНЭЛ



Халамжит хань, үрийн минь сайхан аав, ах дүүгийнхээ хайртай хүү Ишхүү овогтой Түвшинжаргал нь 2016 оны арваннэгдүгээр сарын 30-ны өдөр хүнд өвчний улмаас таалал төгсч, бид бүхэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиолоо.

Ишхүү овогтой Түвшинжаргал нь 1969 оны аравдугаар сарын 01-нд Ишхүүгийн арван сайхан хүүхдийн ес дэх хүү болон мэндэлсэн билээ. Бага насаа эцэг, эхийнхээ гар дээр өнгөрүүлж, өсч торнин, 1977 онд нийслэлийн арван жилийн 76 дугаар сургуульд элсэн орж, төгссөн.

Мөн УБТЗ-ын техникумыг Вагоны техникч мэргэжлээр дүүргээд Улаанбаатар төмөр зам хэмээх их айлын үүдийг татан, ажил амьдралын гараагаа эхэлсэн түүхтэй. Тэрээр УБТЗ-ын Вагон депод үйлчлэгч, техникч, галт тэрэгний мастерын үүрэгт ажлыг тасралтгүй 16 жил нэр төртэй гүйцэтгэж ирсэн. И.Түвшинжаргалын хөдөлмөр зүтгэлийг үнэлэн, "Төмөр замын тэргүүний ажилчин залуу" алтан медалиар шагнаж, урамшуулсан билээ.

И.Түвшинжаргалын инээмсэглэл тодруулсан дүр төрх, ажил хэрэгч, ажилсаг хөдөлмөрч, цэвэрч нямбай, хамт олондоо эелдэг, тусч чанарыг гэр бүл, үр хүүхэд, ач зээ, ах дүү, төрөл төрөгсөд, найз нөхөд, ажлын хамт олон нь үеийн үед дурсан санаж явах болно.

**Ум сайн амгалан болтугай.**

# ФОТО СУРВАЛЖЛАГА



## Өнгөрсөн долоо хоног ГЭРЭЛ ЗУРАГТ



АТГ-аас өнгөрсөн лхагва гарагт Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийг сэжигтнээр тооцож, зарлан дуудах хуудас хүргүүлсэн. Хэрэв ирэхгүй бол албадан ирүүлнэ гэдгээ ч мэдэгдсэн юм. Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг АТГ-т мэдүүлэг өгөхөөр очихдоо өмгөөлөгчийн хамт ирсэн. Түүний өмгөөлөгчөөр өмнө нь Л.Гансүхийг өмгөөлж байсан Ц.Баасандорж ажиллаж байгаа аж.





Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Зудын эрсдэлийн нөхцлийг тооцож, улсын нөөцөөс тодорхой хөрөнгө гаргаж, холбогдох арга хэмжээг авч эхэллээ. Тухайлбал, өнгөрсөн мягмар гарагт аймгуудын нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд шуурхай албаны түргэн тусламжийн автомашиныг хүлээлгэн өглөө. 2016.11.29



Удаан хүлээлгэсэн оюутны сургалтын төлбөрийн зээлийн гэрээ БСШУСЯ арилжааны банкудтай байгууллаа. 2016.11.30



Солонгосын мэдээллийн төв нээгдэв. Уг төвийн нээлт өнгөрсөн мягмар гарагт Монголын залуучуудын холбооны байранд болсон юм. Нээлтэд БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайд У Сун, МЗХ-ны ерөнхийлөгч А.Мөнхбат болон бусад албаны хүмүүс оролцож, санамж бичигт гарын үсэг зурсан юм.



Н.Энхбаярын нэхэмжлэлтэй Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, технологийн төвд тус тус холбогдох захиргааны хэргийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан гомдлын дагуу өнгөрсөн даваа гарагт хянан хэлэлцлээ.






Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн хүний их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөр олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, гэрчилгээ хүлээн авах ёслолын үйл ажиллагаа өнгөрсөн лхагва гарагт АШУҮИС-ийн Соёлын төвд боллоо. Энэхүү ёслолын үйл ажиллагаанд АШУҮИС-ийн захирал Г.Батбаатар, Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн дэд дарга Х.Батсайхан, Азийн хөгжлийн банкны дэргэдэх дээд боловсролын төсөл хэрэгжүүлэх нэгжийн дарга Т.Сувдмаа, Лаос улсын Элчин сайдын яамны дэд тэргүүн Вонфила болон тус сургуулийн багш, оюутнууд оролцсон юм.



Гэрэл зурагчин СТА С.Бадамхандын "Дулаан гар" гэрэл зургийн үзэсгэлэн өнгөрсөн даваа гарагт Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд нээгдлээ. С.Бадамханд нь ОХУ-д гэрэл зургийн мэргэжил эзэмшээд 30 орчим жил уран бүтээлээ туурвиж байгаа аж.






"Тогтвортой хөгжлийг дэмжих хамтын ажиллагаа" сэдэвт Монгол Улсын Засгийн газар- Хөгжлийн түншүүдийн хамтарсан зөвлөлдөх уулзалт өнгөрсөн баасан гарагт болов.




Монгол Улсын 18 дахь Ерөнхий сайд Дашийн Бямбасүрэн өнгөрсөн ням гарагт "IMAX-Лекц"-ийн хүндэт зочноор уригдаж "Хүн байхын учир- Монгол Улсын хөгжлийн гарц-Залуусын үүрэг хариуцлага" сэдвээр лекц уншлаа.





Сүхбаатар дүүргийн VI дугаар сургуулийн сурагчид хоккейн талбайтай боллоо. 2016.11.30

ДЭЛХИЙ

# ДЭЛХИЙН ХЭВЛЭЛҮҮД С.АМАРМАНДАХЫН АСУУДАЛД АНХААРАЛ ХАНДУУЛАВ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

*Тэгвэл энэ хэргийн талаархи мэдээлэл хоёр хөршийн болоод дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн хуудаснаа нийтлэгдэж, олон улсын анхаарлыг татаж эхэллээ. Тэдгээрээс хэд хэдэн мэдээллийн эх сурвалжийг онцолж, уг хэргийн талаар хэрхэн мэдээлснийг энэ удаагийн буландаа онцлон хүргэж байна.*




## Afpbb.com: Сэжигтэнг халдашгүй тусгай эрхийнх нь улмаас баривчлаагүй гэдэг ташаа мэдээлэл

Ийм гарчиг бүхий нийтлэл “Afpbb.com” сайтад нийтлэгджээ. Уг мэдээллийг хөрвүүлбэл, “Монголын алдартай реппэрүүдийн нэг тус улсын уламжлалт хээнүүдийг нэг болох “Хас” бүхий хувцас өмсч, тайзнаа дуулсан гэх шалтгаанаар ОХУ-ын дипломат ажилтанд зодуулж, 10 хоног ухаангүй хэвтэх хэмжээний хүнд гэмтэл авчээ. Энэ талаар дуучны өмгөөлөгч болон цагдаагийн байгууллагаас энэ сарын 2-нд олон нийтэд мэдээллээ. Монголоор “Хар сарнай” гэх хамтлагийн ахлагч Амараа буюу Амармандах Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан урлагийн арга хэмжээнд оролцохдоо монгол үндэсний дээлээрээ гоёж тайзнаа гарсан байна. Улмаар түүний дээлэнд хас хээг шигтгэж өгсөн байжээ. Гэвч тоглолтын дараа ОХУ-ын дипломат ажилтан Амарааг хас хээг дээлэндээ шигтгэсэн гэх шалтгаанаар зодож, биед нь хүнд гэмтэл учруулсан байна. Энэ талаар түүний эцэг “Хүүгийн минь толгой руу цохиж, хүнд гэмтэл учруулсан. Үүний улмаас тархи нь ноцтой гэмтсэн” гэж ярьсан байна. Амараагийн аав болон өмгөөлөгч, мөн “Хар сарнай” хамтлагийн гишүүд ч дуучин залууг “Хай Гитлер” гэж хэлсэн гэх мэдээллийг эрс үгүйсгэж байгаа юм. Хас хээг олон мянган жилийн өмнө Энэтхэгт үүссэн гэж үздэг бөгөөд Адольф Гитлер Нацист Германы бэлгэдэл болгон ашиглахаас ч өмнө буюу эрт үеэс Монголд хэрэглэж ирсэн гэсэн баримт байдаг байна. Харин дэлхийн хоёрдугаар дайны үед Нацист Германы эсрэг дайнд Зөвлөлт холбоот улсын хэдэн зуун энгийн иргэд амь үрэгдсэн түүхтэй юм. Амараагийн өмгөөлөгчийн хэлж буйгаар мөрдөн байцаах ажиллагаа хэт удаашралтай байгаа төдийгүй сэжигтэн этгээд баривчлагдаагүй байгааг онцолсон юм. Тэрбээр “Дипломат ажилтан халдашгүй тусгай эрхтэй байх эсэхээс үл хамааран хэргийн сэжигтэнг Монгол Улсын хууль дүрмийн дагуу баривчлах ёстой” гэж хэлсэн байна. Нөгөөтэйгүүр, цагдаагийн байгууллагаас AFP агентлагт “Хохирогчийн гэмтэл ноцтой биш учраас сэжигтэнг баривчлан саатуулаагүй. Дипломат ажилтны халдашгүй тусгай эрхийн улмаас баривчлаагүй гэдэг ташаа мэдээлэл юм” гэх тайлбарыг өглөө” гэсэн байв.

## dailymail.co.uk: Хас хээ нь баруун Монголын үндсэрхэг үзэлтнүүдийн бэлгэдэл болдог

ОХУ-ын нэгэн дипломат төлөөлөгч Монголын реппэрийг хас тэмдэг бүхий дээл өмсч тайзан дээр гарсан гэх шалтгаанаар биед нь халдаж, комд ортол нь зоджээ. “Хар сарнай” хамтлагийн ахлагч Сүхбаатарын Амармандах Монголын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан урлагийн тоглолтын үеэр ийнхүү зодуулсныг түүний өмгөөлөгч болон цагдаагийн байгууллагаас мэдээлсэн байна. Тоглолтын үеэр Амараа уламжлалт хас хээ бүхий улаан өнгийн монгол дээл өмссөн байжээ. Гэсэн ч тайзнаа гарсныхаа дараахан Оросын дипломат төлөөлөгчид зодуулсан байна. Түүний аав С.Сүхбаатарын хэлснээр дуучин залуу орос хэлээр чөлөөтэй ярьдаг бөгөөд өнгөрсөн жилийн “Авъяаслаг монголчууд” шоу тоглолтод зочноор оролцсон гэнэ. Гэвч харамсалтайгаар зодуулсныхаа дараа 10 орчим хоног эмнэлэгт ухаангүй байгаа ажээ. Амараагийн дуунд Монголын түүх,соёл хийгээд хувь хүний мөн чанар өгүүлэгддэг бөгөөд тэрбээр тайзан дээр байнга хас хээ бүхий хувцас өмсдөг байна. Энэхүү хээ нь баруун Монголын үндсэрхэг үзэлтнүүдийн бэлгэдэл болдог аж. Монгол Улс коммунизмаас 1990 оны ардчилсан хувьсгал руу шилжих хүртэл хэдэн арван жилийн турш хуучин ЗХУ-ын хавчлагад байсан юм. Тиймээс ч хөгжим, кирилл үсгийн цагаан толгойг ашигладаг гэх мэтээр ОХУ-ын соёлын нөлөө олон хэлбэрээр илэрдэг. Ямартай ч, хэргийн талаар Оросын Элчин сайдын яамны вэб хуудсанд хэвлэл мэдээлэл, сошиал сүлжээгээр цацагдсан дээрх хэргийн талаар шалгаж байна гэх мэдээлэл нийтлэгджээ.







## lenta.ru: Дипломат ажилтан согтуурхаж С.Амармандахыг зоджээ

Монголын “Хар сарнай” хамтлагийн ахлагч С.Амармандах хотын Засаг даргын зохион байгуулсан “Аз жаргалтай Улаанбаатар” тоглолтод оролцсоныхоо дараа зодуулжээ. Энэ талаар NEWSru.com мэдээлжээ. Тус тоглолтод уран бүтээлээ толилуулсныхаа дараа дуучин залуу гэртээ харих гэж байхад нь ОХУ-ын Элчин сайдын яамны согтуу дипломат төлөөлөгч лонхоор толгойн тус газарт нь цохиж, гэмтээсэн байна. Үүний дараа найз нарынхаа хамтаар толгой, хөл рүү нь өшиглөж эхэлсний дараа дуучин залуу ухаан алдан унажээ. Одоогоор реппэр эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлж байгаа юм байна. Түүнчлэн, дуучныг зодсон дипломат төлөөлөгч хэн болох нь тодорхойгүй байгаа бөгөөд нэрний эхний үсэг нь А.С гэнэ. Хэргийн бичлэг One Event Hall-ын хяналтын камерт бичигджээ. Зарим мэдээллийн хэрэгсэл дуучны зодуулах болсон шалтгааныг нацист Германы бэлгэдлийг санагдуулам хас тэмдэг бүхий хувцас өмссөнтэй холбон тайлбарлаж байна.

## BBC.com: ОХУ-ын Элчин сайдын яамнаас хэргийн талаар нягталж байгаа гэж мэдэгдэв

Монголын шилдэг реппэрүүдийн нэг хас хээтэй дээл өмсч, тайзан дээр гарсныхаа төлөө ОХУ-ын дипломат төлөөлөгчид комд ортлоо зодуулсан тухай дуучны гэр бүлийнхэн, өмгөөлөгч нь олон нийтэд мэдээллээ. Сүхбаатарын Амармандах тус улсын нийслэл Улаанбаатар хотноо болсон урлагийн арга хэмжээний үеэр ийнхүү бусдад зодуулсан байна. Оросын зарим хэвлэлд дуучин толгойн тус газраа лонхоор цохиулж, нүүр рүүгээ хэд хэдэн удаа өшиглүүлсэн гэж мэдээлсэн бол ОХУ-ын Элчин сайдын яамнаас хэргийн талаар нягталж байгаа гэж мэдэгдсэн юм. Мөн зарим хэвлэл хэргийн мөн чанарыг гажуудуулан, ташаа мэдээлэл түгээж байгааг онцолсон байна. Дуучин залуу тоглолтын үеэр уламжлалт хас хээ бүхий улаан дээл өмсөн тайзнаа гарсан аж. Нацистуудын бэлгэдэл болсон хас хээг Гитлерээс ч өмнө Монголд уламжлалт хээ болгон ашиглаж иржээ. “Хар сарнай” хамтлагийн Амараа гэх нэрээр танигдсан С.Амармандахын дуунд Монголын түүх, соёл, үзэл суртал нэвт шингэсэн байдаг бөгөөд тэрбээр тайзан дээр уран бүтээлээ толилуулахдаа үргэлж хас хээ бүхий хувцас өмсдөг байна. Эртнээс хас хээг Монголын алс баруун хязгаарынхан бэлгэдлээ болгон ашиглаж иржээ. Дашрамд дурьдахад, дуучны өмгөөлөгч болон гэр бүлийнхэн, хамтлагийн гишүүд шоуны үеэр дуучин “Heil Hitler” хэмээн хашгирсан гэх сошиал сүлжээнд тархсан мэдээллийг эрс үгүйсгэсэн байна.







## chinatimes.com: Монгол дуучныг нацисттай андуурч ухаангүй болтол нь зоджээ

Монголын алдартай реппэрүүдийн нэг болох С.Амармандах Улаанбаатар хотод зохион байгуулагдсан урлагийн тоглолтын үеэр хас хээ бүхий дээл өмсч тайзнаа гарчээ. Гэвч ОХУ-ын дипломат төлөөлөгч уг хээг нацистуудын бэлгэдэлтэй андуурч, дуучныг ухаангүй болтол нь зодсон хэрэг гарсан байна. Реппер С.Амармандах тайзан дээр хас хээ бүхий улаан дээл өмсч, дууллжээ. Хас хээ нь Монголын уламжлалт хээнүүдийн нэг юм. Гэвч тус хээг нацистуудын бэлгэдэл хэмээн андуурсан ОХУ-ын Элчин сайдын яамны дипломат төлөөлөгч ихээхэн бухимдаж, лонхоор дуучны толгойн тус газарт нь цохиж, нүүр рүү нь хэд хэдэн удаа өшиглөжээ. Дуучны эцэг С.Сүхбаатар саяхан хэвлэлийн хурал хийж, хүүгээ толгойдоо хүнд гэмтэл авч, тархи нь ноцтой гэмтсэний зэрэгцээ 10 гаруй хоног ухаангүй байгаа талаар мэдээлсэн байдаг. Мөн тэрбээр хэвлэлийн хурлын үеэр Хас хээний зургийг үзүүлж, уг хээ нь Монголын уламжлалт хээ болохыг онцолсон байгаа юм.



# СПОРТ



# Хоёр улаан хуудастай “тулаан”-д ЛОНДОНЫ “ЦЭНХЭРҮҮД” ЯЛЛАА

Н.ПУНЦАГБОЛД

Английн премьер лигийн 14 дүгээр тойргийн хүрээнд өнгөрсөн бямба гарагт хүснэгтийг тэргүүлэгч багуудын тоглолт боллоо. Тэр дундаа Аваргуудын лигт тоглож байгаа багууд бямба гарагт тоглолтоо хийсэн юм. Энэ өдрийн тоглолтоос хамгийн их анхаарал татсан нь “Манчестер Сити” талбайдаа “Челси”-г хүлээж авсан “тулаан” байлаа. Хэрвээ “Сити” хожвол хүснэгтийг тэргүүлэх байсан. Харин “Челси” хожвол Манчестер хотын багаас оноогоор холдох байлаа. Тиймдээ ч маш чухал тоглолт байсан юм. Харин энэхүү тоглолтод “Челси” өрсөлдөгчөөсөө арай илүү байж, “Сити”-г талбайд нь 1:3-аар буулгаж авлаа. Ингэснээр 34 оноотой болж, тэргүүллээ хадгалж үлдлээ. Харин “Сити” 30 оноотой хэвээр үлдэж, дөрөвдүгээр байр руу ухарч байгаа юм. Тоглолтын 45 дахь минутад Гарри Кейхилл өөрийнхөө хаалганд авто гоол оруулсан.

Гэвч хоёрдугаар хагаст “Челси” бүрэн утгаараа илүүрхэж, сөрөг довтолгоогоор гурван ч гоол оруулсан. 60 дахь минутад Фабрегасын өгсөн алсын дамжуулалтыг Диего Коста гайхалтай тогтоож авч, хаалганд оруулснаар тооны харьцааг тэнцүүлсэн. Ингэснээр Коста премьер лигт энэ улиралд 11 гоолтой болж, мэргэн буучийн жагсаалтыг тэргүүлсэнхэвээрүлдлээ.Харин 70 дахь минутад Виллиан мөн л сөрөг довтолгоог гүйцээж, багтаа тэргүүлэл авчирсан юм. Тэгвэл Эдин Азар 90 дэх минутад нэгийг нэмж, лигийн найм дахь гоол оруулснаар “Сити”-гийн тэнцүүлэх боломж хайж байсан өчүүхэн найдварыг унтраасан юм. Улмаар цагийн төгсгөлд “Манчестер Сити”-гийн довтлогч Сержио Агуэро эсрэг багийн хамгаалагч Давид Луйзын эсрэг аюултай такл хийснээр тоглогчдын хооронд багагүй үймээн гарсан. Спортын бус үйлдлийнхээ төлөө Агуэро улаан хуудас авч, талбайг чөлөөлсөн бол энэ дүйвээнээр Фернандиньо Испани тоглогч Фабрегасыг багалзуурдсаныхаа төлөө мөн л хөөгдсөн юм.



## Санчес хет-трик хийж, “Арсенал” бутниргэлээ

Сүүлийн үед гайхалтай тоглолтыг үзүүлж байгаа Лондоны “Арсенал” клуб нэг хотын баг болох “Вест хэм”-ийн талбайд зочилж, 1:5-аар бутниргэлээ. Ингэснээр 31 оноотой болж, хүснэгтийн хоёрдугаар байр руу орж ирлээ. “Ливерпүүл”-ийн тоглолтоос хамаарч энэ байрлал өөрчлөгдөж болно. Ямар ч байсан тэд гайхалтай ялалтыг авч, дөрөвдүгээр байрнаас ховхорлоо. Энэ тоглолтод “Арсенал”-аас Алексис Санчес шилдэг нь байж, 72, 80, 86 дахь минутад гуран гоол оруулсан. Үндсэндээ тэрбээр 14 минутын дотор хет-трик толилуулж, премьер лигт энэ улиралд 11 гоолтой болсноор Костагийн хамтаар мэргэн буучийн жагсаалтыг тэргүүлж байна. Тэгвэл Месут Өзил 24 дэх минутад нэгийг нэмэрлэж, Окслейд-Чемберлен 84 дэх минутад үүргээ гүйцэтгэжээ. Талбайн эздээс 83 дахь минутад Энди Кэрролл нэр төрийн ганц гоол оруулсан. “Вест хэм” энэ тойрогт хожигдсоноор 12 оноотой, 17 дугаар байрт бичигдэж байна. “Халл Сити”-гийн тоглолтоос хамаараад тэд байр уруудах ч магадлалтай юм.

**Бусад тоглолтын үр дүн:**

Вест Бромович 3-1 Уотфорд
Тоттенхэм 5-0 Соунси
Сандерланд 2-1 Лестер
Сток Сити 2-0 Бөрнли
Кристал Палас 3-0 Саутгэмптон

## “Лейпциг”, “Хоффенхайм”-ын хожигдоогүй цуврал үргэлжилсээр...

Германы Бундес лигийн 13 дугаар тойргийн ихэнх тоглолт өнгөрсөн бямба гарагт боллоо. Энэ тойрогт хожигдоогүй байсан хоёр баг болох “Лейпциг” болон “Хоффенхайм” клубүүд тоглолтоо хийсэн. Хүснэгтийг тэргүүлж байгаа “Лейпциг” клуб энэ тойрогт талбайдаа “Шальке”-г хүлээж авч, 2:1-ээр буулгаж авлаа. Ингэснээр 33 оноотой болж, тэргүүн байраа хадгалж үлдсэн юм. Тоглолтын хоёр дахь минутад Вернер торгуулын цохилтоор тооны харьцааг нээсэн бол 31 дэх минутад Колашинац тэнцүүлжээ. Гэвч 47 дахь минутад өнөөх Колашинац өөрийнхөө хаалганд авто гоол оруулснаар багаа хөөдсөн байна. Ийн “Лейпциг” 10 хожиж, гурав тэнцсэн амжилттай тэмцээнийг үргэлжлүүлж байна. Тэгвэл өөр нэг хожигдоогүй яваа баг болох “Хоффенхайм” энэ тойрогт “Кёльн” клубыг хүлээж авч, 4:0-ээр буулгаж авлаа. Ингэснээр 25 оноотой болж, дөрөвдүгээр байрт бичигдэж байна. Тоглолтын 8, 67 дахь минутад Вагнер хоёрыг хийсэн бол Толян 39, Ут 89 дэх минутад тус бүр нэгийг нэмжээ.

**Бусад тоглолтын үр дүн:**

Вердер 2-1 Инголыштадт
Вольфсбург 2-3 Херта
Боруссия Дортмунд 4-1 Боруссия Мюнхэнгладбах
Байер 1-1 Фрайбург

## “Эль Класико” тэнцээгээр өндөрлөлөө

Дэлхийн сая сая хөгжөөн дэмжигчдийн анхаарлын төвд байсан Испанийн алдарт “Барселона” болон “Реал Мадрид” клубын ээлжит “Эль Класико” өнгөрсөн бямба гарагт боллоо. Испанийн Ла лигийн 14 дүгээр тойрогт учраа таарсан хоёр багийн тулаанд “Барселона” заавал хожих даалгавартай байсан. Тэгж байж Эзэн хааны багаас есөн оноогоор хоцорчихолгүй үлдэх учиртай байлаа. Харин “Реал”-д тэнцээ авсан ч хангалттай байсан. Тэнцлээ гэхэд “Барса”-гаас зургаан онооны илүүгээ хадгалаад үлдэх байсан. Тэгвэл “Камп ноу” цэнгэлдэхэд болсон хоёр агуу багийн тулаан 1:1-ээр тэнцэж өндөрлөлөө. Ингэснээр “Реал”-ын зорилго биелж байгаа юм. Тоглолтын 53 дахь минутад Суарез гоолдож, Ла лигт энэ улирлын ес дэх гоолоо оруулсан. Тэгвэл 90 дэх минутад Сержио Рамос хариуг нь барьж, тэнцүүлснээр багтаа нэг оноо авчирсан юм. Ингэснээр “Реал” 34 оноотой болж, тэргүүллээ хадгалсан. Мөн энэ улиралд ганц ч хожигдоогүй байгаа цувралаа ч хадгалж үлдлээ. Харин “Барселона” 28 оноотой болж, хоёрдугаар байрт бичигдэж байна. Тэргүүлэгчийн араас нэхэж явсан “Севилья” клуб энэ тойрогт “Гранада”-гийн талбайд 2:1-ээр хожигдсоноор 27 оноотой хэвээр үлдэж, гуравдугаар байрт бичигдэж байна. Тэгвэл “Атлетико” талбайдаа “Эспаньол”-той хуурай тэнцсэнээр 25 оноотой болж, дөрөвдүгээрт байрт жагсч байгаа юм.

## Роналдо, Месси, Грзманн нар FIFA-гийн шилдэг тоглогчийн төлөө тунаж үлдлээ

“Барселона”-гийн хөдөлгөгч хүч Лионель Месси, “Реал”-ын супер од Криштиано Роналдо, “Атлетико”-гийн мэргэн бууч Антуан Гризманн нар FIFA-гийн оны шилдэг тоглогчийн шалгаруулалтын сүүлчийн шатанд тунаж үлдлээ. Гарет Бейл, Луис Суарез, Златан Ибрахимович, Роберт Левандовски зэрэг дэлхийн шилдэг 23 тамирчны дундаас эдгээр гурван хөлбөмбөгч эцсийн шатны шалгаруулалт тунаж үлдээд байгаа юм. Роналдогийн хувьд 2016 онд “Реал”-ын хамтаар Аваргуудын лигт түрүүлж, Португалын шигшээтэй Европын аварга болсон билээ. Тэгвэл Гризманн “Атлетико”-тай Аваргуудын лигт финалд үлдэж, Францын шигшээн хамтаар Европын аваргад ч мөн шигшээд шалгарсан билээ. Тэгвэл Месси “Барселона”-гийн хамтаар Ла лигт түрүүлсэн бол Аргентины шигшээтэй “Копа Америка” тэмцээний шигшээд шалгарсан юм.

MMINFO. ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ






# СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН



# М.УРАНЦЭЦЭГ

## Токиогийн "ИХ ДУУЛГА" тэмцээнээс алтан медаль авсан анхны тамирчин боллоо

Н.БОЛД

Японы нийслэл Токио хотноо жүдо бөхийн "Их дуулга" ангиллын тэмцээн энэ сарын 2-4-ний өдрүүдэд амжилттай болж, өндөрлөлөө. Чансаагаараа Олимпийн наадам болоод дэлхийн аварга шалгаруулах тэмцээний дараа орох, "Бага дэлхийн аварга" хэмээх тодотголтой энэхүү тэмцээнд өнөө жил дэлхийн 41 орны эрэгтэй 155, эмэгтэй 132, нийт 287 тамирчин оролцсон юм. Харин манай улсаас эрэгтэй найм, эмэгтэй дөрөв, нийт 12 тамирчин хурд хүч, ур ухаанаа сорьсон юм. Японоос энэхүү тэмцээнд зохион байгуулагч орон гэдэг утгаараа нэг жинд дөрөв, нийтдээ 56 тамирчнаа барилдуулсан. Тиймдээ ч жүдо бөхийн хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч Японы шилдэг тамирчидтай барилдах боломж бусад орны жүдочдод олдсон гэхэд болно. Тэгвэл чансаа өндөр энэхүү тэмцээнд оролцсон манай 12 тамирчин нэг алт, хоёр хүрэл медаль хүртсэн амжилтаараа багийн дүнгээр гуравдугаар байрт шалгарлаа.




### Хөнгөн жингийнхэн нүүр тахаллаа

Тэмцээний эхний өдөр хөнгөн жингийнхэн Монголын багийн авсан гурван медалийг хүртсэн. Эмэгтэйчүүдийн хамгийн хөнгөн жин болох 48 кг-д зодоглосон Дэлхийн аварга, Гавьяат тамирчин М.Уранцэцэг урамтай сайхан барилдаж, алтан медаль хүртлээ. Ингэснээр тэрбээр "Бага дэлхийн аварга" буюу Токиогийн Гранд сламаас алтан медаль хүртсэн анхны монгол жүдоч болсон юм. Тэрбээр дэлхийн аваргад түрүүлсэн анхны эмэгтэй жүдоч болж байсан бол энэ удаад бүх жүдочдоос анхдагч нь болж байгаа юм. Манай бөх эхний тойрогт Чилийн Мэри Диг ялсан бол хэсгийн аваргын төлөө Солонгосын Кан Юү Жоныг давсан юм. Харин хагас шигшээд Японы Тонаки Фунаг торгуулаар буулгаж авсан. Тэгвэл финалд Солонгосын шилдэг бөх Жон Бу Кёнтэй тулсан. Тэрбээр хагас шигшээд Казахстаны нэрийн өмнөөс барилдаж байгаа манай Г.Отгонцэцэгийг ялсан байсан юм. Мөн Олимпийн наадмын хэсгийн аваргын төлөөх барилдаанд М.Уранцэцэг түүнд ялагдаж байсан билээ. Харин энэ удаад манай бөх хариугаа авч, финалд өрсөлдөгчөө торгуулиар буулгаж авснаар алтан медалийн эзэн болж, Японы тэнгэрт төрийн далбаагаа мандуулж, төрийн дууллаа эгшиглүүлж чадсан юм. Эрэгтэй, эмэгтэй нийт 14 жинд аварга тодрохоос японaugчууд 10-ыг нь өөрийн болгосон. Харин үлдсэн дөрвөн алтын нэгийг нь манай улс авч чадсан нь ямархуу чансаа өндөртэй, шилдэг тамирчидтай вэ гэдгээ баталсан хэрэг боллоо. Мөн эхний өдөр эмэгтэйчүүдийн 57 кг-ын жингийн шилдэг бөх, Олимпийн наадмын мөнгөн медальт, Гавьяат тамирчин Д.Сумъяа хүрэл медаль хүртсэн юм. Манай бөх эхний тойрогтоо хийлж, хоёрдугаар тойрогт Тайландын Юүриког цэвэр ялсан бол хэсгийн аваргын төлөө Японы Ишикава Мегүмиг буулгаж авсан билээ. Харин хагас шигшээд мөн л Японы бөх Ёшидо Цукасатай барилдсан ч ялагдсан. Гэвч хүрлийн төлөө Францийн Хелене Ресивачийг буулгаж авснаар Токиогийн "Их дуулга" тэмцээний хошой хүрэл медальтан боллоо. Манай бөх 2015, 2016 онд дараалж медаль дээр бууж байгаа юм. Эрэгтэйчүүдийн хувьд 66 кг-д тун ч амжилттай барилдаж байгаа Д.Алтансүх Бага дэлхийн аваргаас хүрэл медаль хүртлээ. Д.Алтансүхийн хувьд эхний тойрогтоо хийлж, хоёрдугаар тойрогт Испанийн Гайтеро Мартиныг ялсан. Гэвч хэсгийн аваргын төлөө Японы Такажо Томофүмид базари үнэлгээгээр ялагдсан юм. Ингэснээр торгуулийн тойрог руу орж, Солонгосын Ан Баултай учраа таарсан. Рио-2016 наадмын мөнгөн медальтай тэрбээр энэ жингийн хүчтэй өрсөлдөгчийн нэг. Гэвч манай Д.Алтансүх түүнийг цэвэр ялж, улмаар медалийн төлөө Исода Норихитог юүко үнэлгээгээр буулгаж авч, хүрэл дээр буусан юм. Эрэгтэйчүүдийн 60 кг-д манай шилдэг бөх Д.Амартүвшин зодоглосон ч хүрлийн төлөө Оросын Роберт Мшвидобадзег баралгүй, шагналт тавдугаар байрт шалгарсан юм.

> ...Японоос энэхүү тэмцээнд зохион байгуулагч орон гэдэг утгаараа нэг жинд дөрөв, нийтдээ 56 тамирчнаа барилдуулсан. Тиймдээ ч жүдо бөхийн хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч Японы шилдэг тамирчидтай барилдах боломж бусад орны жүдочдод олдсон гэхэд болно...

### Дунд болоод хүнд жингийнхэн том тэмцээний "утаа" үнэрлэлээ

Эрэгтэйчүүдийн 73, 81, -100, эмэгтэйчүүдийн 63, 70 кг-д манайхаас долоон бөх барилдсан. Эмэгтэйчүүдийн хүнд жинд бол огт бөх барилдаагүй. Энэ дундаас 73-т барилдсан Б.Батгэрэл, 81-ийн Н.Дагвасүрэн нараас бусад нь шинэ залуу бөхчүүд. Тиймдээ ч тэднээс нэг их зүйлийг хүлээх боломж ч байгаагүй. Залуу тамирчид маань үндсэндээ том тэмцээний "утаа" үнэрлээд л ирлээ. 73-т барилдсан Б.Батгэрэлийн хувьд эхний тойрогтоо Канадын Брэдли Ланглойсыг буулгаж авсан ч хоёрдугаар тойрогт Узбекстаны Бобоевт ялагдсан. Харин 81-ийн Н.Дагвасүрэнгийн хувьд эхний тойрогтоо хийлсэн ч хоёрдугаар тойрогт Солонгосын Ли Хуй Жуныг барсангүй. -100 кг-ын хувьд О.Хангал, Д.Ишдорж гэсэн хоёр залуу бөх барилдсан ч эхний хол явсангүй. Д.Ишдоржийн хувьд эхний тойрогтоо Пакистаны бөхийг ялсан ч хоёрдугаар тойрогт Оросын шилдэг бөх Кирилл Денисовт ялагдсан. Гэхдээ тэрбээр дэлхийн шилдэг бөхтэй барилдаад үзчихсэн гэдэг нь бас нэг том туршлага болсон болов уу. Эмэгтэйчүүдийн 63 кг-д М.Даваасүрэн барилдсан ч эхний тойрогтоо Японы Мегүми Цуганег барсангүй. Харин 70 кг-д зодоглосон М.Баяртуулын хувьд Тайванийн бөхөд ялагдсанаар тэмцээнээ дуусгасан билээ. Гэхдээ манай шинэ залуу тамирчид энэ том тэмцээнд оролцсон нь туршлага боллоо.

### Японжууд 56 медалийн 35-ыг нь өөрсдөө авлаа

Токиогийн "Их дуулга" тэмцээнийг багийн дүнгээр мэдээж Японы шигшээ тэргүүлсэн. Жин тус бүрийн медальтнуудад очих ёстой 56 медалийн 35-ыг нь тэд өөрсдөө авлаа. Ингэхдээ 14 алтан медалийн 10-ыг нь өөрийн болгосон. Харин мөнгөн медаль есийг хүртсэн бол 16 хүрэл авлаа. Японжуудаас илүү гарч алт авсан улс гэвэл Орос, Монгол, Серби, Австрийн жүдочид байлаа. Солонгос, Францийн шилдэг жүдочид хоёр хоёр мөнгөн медаль дээр л буусан юм. Мөн энэ тэмцээнд оролцсон 40 гаруй улсаас ердөө 20 нь ямар нэг байдлаар медаль авлаа. Японыг хасвал 19 орон л медаль хүртсэн юм.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Олимпийн бус жингийн ДАШТ-д оролцох бүрэлдэхүүн тодорлоо

Чөлөөт бөхийн олимпийн бус жингийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн Унгарын нийслэл Будапешт хотын "Syma Csarnok" спортын ордонд энэ сарын 10-11-ний өдрүүдэд болох билээ. Тэгвэл энэхүү тэмцээнд оролцох манай шигшээ багийн бүрэлдэхүү тодорхой болжээ. Тус тэмцээн сонгомол барилдааны 71, 80 кг, эрэгтэй чөлөөт бөхийн 61, 70 кг, эмэгтэй чөлөөт бөхийн 55, 60 кг-ын жингүүдээр болно. Энэ удаагийн ДАШТ-ий эрэгтэйчүүдийн 61 кг-ын жинд ОУХМ, "Гацуурт-Олимп" клубын тамирчин Т.Түвшинтулга оролцох бол 70 кг-д ОУХМ, "Хилчин" спорт хорооны тамирчин Б.Батзориг барилдана. Тэгвэл эмэгтэйчүүдийн 55 кг-д ОУХМ, "Дархан-Хасу-Мегарстарс" клубын тамирчин Д.Отгонцэцэг барилдахаар болсон бол 60 кг-д ОУХМ, "Цастын барс" клубын тамирчин Б.Шоовдор зодоглох юм. Харин дасгалжуулагчдаар Цэндийн Баярсайхан, Цэрэндалайн Баярсайхан, Паламын Чулуунбаатар нар оролцохоор шигшээ багийн бүрэлдэхүүд багтжээ.

## Хүндийн өргөлтийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээн болно



Монголын хүндийн өргөлтийн холбооноос Хүндийн өргөлтийн шилдэг тамирчин, дасгалжуулагч Ш.Энхсайханы нэрэмжит өсвөрийн аварга шалгаруулах тэмцээнийг энэ сарын 10-11-ний өдрүүдэд Спортын төв ордонд зохион байгуулахаар болжээ. Энэхүү тэмцээнийг Ш.Энхсайхан багшийн хүү Эрдэмбилэг, н.Чинзориг нар ивээн тэтгэн зохион байгуулах аж. Тэмцээнд 1999 оны нэгдүгээр сараас төрсөн өсвөрийн тамирчид оролцох бөгөөд эрэгтэй, эмэгтэй тус бүр найман жинд аваргууд тодорно. Тэмцээний техникийн зөвлөгөөн арванхоёрдугаар сарын 9-ний өдрийн 15.00 цагаас Спортын ордонд байрлах Хүндийн өргөлтийн Үндэсний шигшээ багийн зааланд болох юм байна.

## Казах бөхийн тэмцээн Монголын баг мөнгөн медаль хүртжээ

Казах бөхийн "Еуразия Барысы" тэмцээн энэ 1-нд Казахстаны Алмата хотноо болж, Монгол Улсын баг шигшээд дэвжээний эздэд 2-6-гаар ялагдан, мөнгөн медаль хүртлээ. Дөрөвдэх жилдээ болж буй уг тэмцээнд Монгол, ОХУ, Гүрж, Польш, Тажикистан, Узбекистан, Турк, Казахстаны баг өрсөлдсөн байна. Түрүүлэх хамгийн магадлалтай багийн тоонд Монгол, Гүрж, Казахстаныг нэрлэж байсан аж. Тэр ч ёсоор Казахстан түрүүлж, Монгол, Гүржийн багууд удаалсан байна.

## А.Ичинноров бодибилдингийн дэлхийн аварга боллоо

Тайландын Бангкок хотноо болж буй 2016 оны бодибилдинг, фитнессийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний эмэгтэйчүүдийн Фитнес төрөлд манай тамирчин А.Ичинноров дэлхийн аварга боллоо. "Perfect" клубийн тамирчин тэрбээр энэ оны Азийн аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль хүртээд байсан юм. Өнөөдөр өндөрлөх бодибилдинг, фитнессийн ДАШТ-д манай 16 тамирчин өрсөлдөж байгаагаас өчигдөр өдрийн байдлаар эмэгтэйчүүдийн Фитнес төрөлд А.Ичинноров алт, Б.Бадамсүрэн хүрэл медаль хүртээд байсан юм. Мөн эрэгтэй бодибилдингийн төрөлд амжилттай оролцож байгаа бөгөөд 70 кг-ын ангилалд Л.Саруулбат хүрэл медаль хүртсэн. Бодибилдинг, фитнессийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн нийт 36 ангилалд болдог. Манай тамирчид бодибилдинг, атлетик, фитнес, модель, спорт модель гэсэн төрлүүдэд өрсөлдсөн юм.



NO STRESS

ГОЁЛ - 2017

# Топын хэмжээний загвар өмсөгчгүй “Гоёл 2017”

















Гэрэл зургийг Г.ГАРУУЖИН



Э.ТУУЛ

Монголын дизайнеруудын холбооноос зохион байгуулдаг “Гоёл” наадам 29 дэх удаагаа Соёлын төв өргөөнд боллоо. Энэ жилийн наадамд О.Уянга, О.Пүрэвдулам, Х.Бадамгэрэл, Х.Уянга, Г.Уранцэцэг, С.Ариунбилэг, Э.Сэлэнгэ нарын топ моделиуд оролцсон. Жил бүрийн “Гоёл” болох үеэр энэ жилийн Топ модель хэн байх бол гэсэн таамаг өрнөдөг. Гэвч ийм таамаг энэ жил өрнөсөнгүй “Гоёл” наадам ч болоод өнгөрлөө. Угтаа бол жил болгон топ модель шалгаруулдаг байсан “Гоёл” наадам энэ жил ТОП-гүй хоцорлоо. Учрыг тодруулбал, “Гоёл” наадмыг зохион байгуулагчид топын хэмжээнд хүрэх загвар өмсөгч байхгүй гэж дүгнэсэн тул энэ жил ТОП модель тодорсонгүй. Харин бусад номинациудын эзэд тодорсон юм. Тухайлбал, монгол хувцас, загварын хамгийн томд тооцогддог шалгаруулалтын шилдэг дизайнер буюу Гранпри шагналыг "Эртний монгол хийц" загварын товчооны дизайнер



О.Уранцэцэг хүртсэн бол шилдэг эмэгтэй загвар өмсөгчөөр Д.Долгион, эрэгтэй загвар өмсөгчөөр н.Азжаргал, шилдэг фото моделиор О.Ариунзул нар шалгарчээ. Ингээд “Гоёл 2016” наадмын шилдгүүдийг танилцуулъя.

Шилдэг эмэгтэй загвар өмсөгч: Загвар өмсөгч Д.Долгион
Шилдэг эрэгтэй загвар өмсөгч: Загвар өмсөгч н.Азжаргал
Фото модель: “Шилмэл загвар” агентлагийн загвар өмсөгч О. Ариунзул, “Монгол модель” агентлагийн загвар өмсөгч Н. Ану
Дэд байр: “Шилмэл загвар” агентлагийн загвар өмсөгч н.Алтантуяа
Ирээдүйтэй загвар өмсөгч: Загвар өмсөгч Г.Бүрд
Шилдэг загвар зохион бүтээх товчоо: “Master Dodo” ХХК
Гоёлын хувцасны шилдэг дизайнер: “Precious fashion house” дизайнер Цээгий, Адъяа
Үндэсний хувцасны шилдэг дизайнер: Үйлдвэрлэл урлагийн сургуулийн дизайнерийн багш н. Энхтуяа
Өдөр тутам, чөлөөт, амралтын хувцасны шилдэг дизайнер: “Эвсэг” ХХК-ны дизайнерууд
Уламжлалд хувцасны шилдэг дизайнер: “Ур-Ундрах” ХХК-ны дизайнер н.Баасансүрэн
Шилдэг залуу дизайнер: “Урангоо Идэр” салоны дизайнер И.Урангоо
Шилдэг зурагчин: н.Цоггэрэл
Шилдэг makeup artist: "Наруми" салоны Г. Нармандах
Шилдэг үсчин: "Vidal" салоны захирал, Монгол улсын мастер үсчин Д. Одонгоо
Наадмын ивээн тэтгэгч байгууллагын шагнал: Загвар өмсөгч н. Азжаргал, н. Золбоо, н. Хулангоо, н. Адъяа
Тусгай байр: “Жи Энд Эс” ХХК-ийн дизайнер С. Ганзориг “Сомо” брэнд, “Mon line” ХХК-ийн дизайнер н. Цэрэнханд, н. Өнөрбат













ДУУЛГАХ СОНИН

## Хагас нүцгэн хүмүүс хүчирхийллийн эсрэг нэгдэв



Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд зориулсан "Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн төлөө" уриатай хагас нүцгэн шоу боллоо. Энэхүү загварын болон уран зургийн үзэсгэлэнд хүндэт зочноор кёкшүюзан Д.Батбаяр, “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлгийн хөтлөгч П.Анужин, "Ажигана" компанийн захирил Э.Туул, жүжигчин С.Өлзийхүү болон гадаад, дотоодын чинээлэг эрхмүүд хүрэлцэн ирсэн байв. Хагас нүцгэн загварын шоуны үеэр зураач, дизайнер Э.Халиун “Сөрөхүй” хэмээх уран зургийн үзэсгэлэнгээ дэлгэсэн юм. Зарим зургаараа бусад цочрол, айдас мэдрүүлсэн бүтээлүүд байсныг онцлох нь зөв болов уу. Мөн энэхүү шоунд дуучин Э.Энхзол, “GUYS” хамтлагийнхан уран бүтээлээ хүргэсэн бөгөөд шоуны гол дүр топ модель Г.Уранцэцэг буюу Урнаа “Semi Nude Art Fashion Show” – Хагас Нүцгэн Урлагийг үзүүлсэн нь зочид төлөөлөгчдөд тун ч их таалагдсан юм. Ийнхүү хагас нүцгэн хүмүүс нэг өдөр хүчирхийллийн эсрэг нэгдлээ.